MMINFO.

18 дахь жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,102.326... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.08.30. Мягмар. №152 (4522) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




УЛС ТӨР

Д.ЭРДЭНЭБАТ: ЭРҮҮГИЙН ХУУЛИЙГ ХОЙШЛУУЛБАЛ ЭНЭ ЗАСГИЙН ГАЗРЫГ ОГЦРУУЛНА

II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙГ ЗОГСООХ НЬ ЗӨВ, БУРУУ

V нүүрт

Дугаарын 60 мөр

## Байр түрээслэж бизнес хийгчдээс татвар аваач

Н.ПУНЦАГБОЛД

Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал нэлээд хүнд шат руугаа орчихсон байгаа. Үүнийг эдийн засагчид ч хэлж байна. Эрх барьж байгаа МАН-ынхан бол бүр “давс” нэмээд, илүү сүржигнээд байгаа. Гэхдээ хэн нь юу гэж ярихдаа гол биш, эдийн засгаа одоо л эрүүлжүүлж авахгүй бол бид хэцүүхэн байдалд тун удахгүй орно гэдэг нь үнэн. Харин эдийн засгийг эрүүлжүүлэхийн тулд бид юу хийх ёстой вэ. Одоогоор Засгийн газар төсөв хэмнэх аргыг нэн түрүүний сонголт болгож, чадах бүхнээ хийх гэж оролдож байна. Төсөв хэмнэх “дайн”-д хэн илүү хохирох гээд байгааг харвал ард түмэн. Мэдээж төсвийн хэмнэлт хийхдээ хэт өндөр цалинтай дарга нарын халаасалж буй мөнгөний тодорхой хувийг төр авч үлдэх гэж байна. Оюутнуудад өгч байгаа халамжуудыг зогсоохоор болж байгаа бололтой. Дээрээс нь дарга нарын утасны мөнгө, гадаад руу явах зардал гэх мэт үр ашиггүй урсгадаг мөнгийг танах сураг байсан. Гэх мэт олон зөв шийдвэрүүд гарсан.

Үргэлжлэл нь III нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

# 3-ХАН САЯ ХҮНИЙГ ЯДУУ АМЬДРУУЛЖ БАЙЖ БАС БАЙГАЛИЙН БАЯЛГАА ХАРАМЛАХ УУ




Шог зургийг С.Цогтбаяр

Дэлгэрэнгүйг III нүүрнээс




УЛСТӨРЧ ЯРЬЖ БАЙНА

## Ж.БАТЗАНДАН: НАМАЙГ НАМЫН ДАРГА БОЛЧИХ ВИЙ ГЭЖ НОЙРГҮЙ ХОНОЖ БАЙГАА ХҮМҮҮСТ НЭГ Л ЗҮЙЛ ХЭЛНЭ

Ж.ОТГОН

*УИХ-ын гишүүн Ж.Батзандантай цаг үеийн асуудлаар ярилцлаа.*

**-АН-ыг шинэчлэх шаардлагатай байна гэцгээж байгаа. Та ямар шинэчлэл хүлээж байгаа вэ?**

-Шинэчлэл гэдэг бол хоёр янз. Нэгдүгээрт, өнгөн засал буюу нүүрээ будаад цаашаа явах өнгөн шинэчлэл хийх. Хоёрдугаарт, агуулгын шинэчлэл хийх буюу АН-ыг үндсээр нь өөрчлөх гэсэн хоёр хэлбэрийн шинэчлэл байна. Шинэчлэл ярьж байгаа хүмүүсийн зарим нь нэг дэх замын тухай ярьж байгаа. Ялангуяа манай фракцийн дарга нар нүүрээ будаад, косметик мэс засал хийгээд АН-ыг цааш нь авч явахыг хүсч байна. Манай залуу үе буюу 70-80-аад оныхон намаа агуулгын хувьд үндсээр нь шинэчлэх асуудлыг ярьж байгаа. Тэгэхээр шинэчлэлийн тухай ярьж байгаа хүмүүс дотроо 2-3 хэсэгт хуваагдаад байна.

**-Та аль хэсэгт нь багтаад байгаа юм бэ?**

Үргэлжлэл нь IV нүүрт

## ДЭЛХИЙН СВИЧ ЭКСПО 2016

सत्यमेव जयते

СВИЧ 2016 – Олон Улсын Үзэсгэлэн болон Эрчим хүч үйлдвэрлэл, шинэ бүтээлийн Электрон Инженерчлэлийн Дээд Хэмжээний Уулзалт Гужарат мужийн Вадодара-д 2016 оны аравдугаар сарын 6-10-нд зохион байгуулагдана. Уг үзэсгэлэн, арга хэмжээг Гужарат мужийн Засгийн газрын Эрчим хүч, Нефть химийн департмент зохион байгуулж байгаа ба Гужаратын Аж үйлдвэрүүдийн холбоо зохион байгуулагч, хэрэгжүүлэгч түнш нь юм.

СВИЧ 2016 нь шинэ бүтээлийн тусгай хэсэгтэй байх ба Электрон Инженерчлэлийн шинэ бүтээлийн зохиогчдод өөрсдийн бүтээлээ дэлгэн үзүүлэх үзэсгэлэнгийн талбайг тус улсын хэмжээнд анх удаа тусгайлан гаргана. Хөрөнгөоруулагчид,Банкзэрэгсанхүүжилтийн эх үүсвэрийг электроникийн үйлдвэрт нээх мэдээлэл солилцох инкубаторуудын форумыг бас зохион байгуулна.

Дэлхийн өнцөг булан бүрээс 100,000 гаруй зочид энэхүү арга хэмжээнд оролцох гэж байна. Зочдын дунд 8,500 гаруй өндөр мэргэжлийн стратегийн түвшний худалдан авагчид дэлхийн өнцөг булан бүрээс ирэх ба тэдгээр зочдын чанарыг хангахын тулд зардлыг нь манай тал гаргана. Эдгээр худалдан авагчид нь үзэсгэлэн гаргагч 1,000 хүнтэй уулзаж харилцах боломжтой байна.

Энэтхэгт болох энэхүү дэлхийг хамарсан арга хэмжээнд Монгол үйлдвэрлэл эрхлэгчид, бизнесийн байгууллагуудыг урьж байна.

**СВИЧ 2016-ийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл http://www.switchglobalexpo.com/ вэб хуудаст зочлохыг хүсье.**

**ХААН банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2240.00 | 2273.00 | ФУНТ | 2855.00 | 2993.00 |
| ЕВРО | 2452.00 | 2552.00 | РУБЛЬ | 32.10 | 36.00 |
| ИЕН | 21.47 | 22.40 | ЮАНЬ | 332.00 | 339.40 |

**Худалдаа хөгжлийн банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2240.00 | 2273.00 | ФУНТ | 2912.00 | 3010.00 |
| ЕВРО | 2484.00 | 2569.00 | РУБЛЬ | 33.61 | 36.78 |
| ИЕН | 21.71 | 22.53 | ЮАНЬ | 333.00 | 345.90 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

## Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргаар Ц.Баярсайханыг томилов

Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргаас өөрийн хүсэлтээр татгалзахаар болсноо мэдэгдсэн П.Цагаан өчигдөр өөрийнх нь оронд томилогдож буй УИХ-ын гишүүн, ЭЗБХ-ын дарга асан Ц.Баярсайханд тамгаа гардуулан өглөө. Тэрбээр УИХ-ын гишүүнээр дөрвөн удаа сонгогдон ажиллаж, улмаар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны дарга, Барилга, хот байгуулалтын сайдаар ажиллаж байсан туршлагатай хүн билээ. Эдийн засагч мэргэжилтэй Ц.Баярсайханыг Ерөнхийлөгчийн Тамгын газарт ажиллах боломжтой, зөв хүн томилогджээ хэмээн олон хүн сайшааж байна. Харин Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргаар 2009 оноос хойш ажиллаж байсан П.Цагаан ажлаа өгөхөөр болсноо өнгөрсөн долоо хоногт мэдэгдсэн. Тэрбээр "АН-аа нэг цул байх ёстой гэж үзэж ирсэн байр сууриа дахин нотолж, хуримтлуулсан төрийн болон улс төрийн ажлын туршлага, эдийн засаг, улс төр, хууль цааз, гадаад харилцааны мэдлэг боловсролоо Ардчилсан намынхаа шинэтгэлийн үйлсэд зориулах нь зүйтэй гэж шийдсэнээ та бүхэнд мэдэгдэж байна" гэж хэвлэлийн бага хурал хийх үеэрээ мэдэгдэж байсан юм.

MMINFO.
МОНГОЛЫН МЭДЭЭ
18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО
Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158
Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012
Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454
Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873
Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796
Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710
Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510
Э.САЙНЗАЯА 99197866
Дугаарын эрхлэгч Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

БҮЛГИЙН ХУРАЛДААН

# Д.ЭРДЭНЭБАТ: ЭРҮҮГИЙН ХУУЛИЙГ ХОЙШЛУУЛБАЛ ЭНЭ ЗАСГИЙН ГАЗРЫГ ОГЦРУУЛНА

Ж.ОТГОН



УИХ-ын ээлжит бус чуулганы үеэр Эрүүгийн болон зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр оруулж ирсэн. Уг нь Эрүү болон Зөрчлийн тухай хуулиуд ирэх сарын 1-нээс хэрэгжиж эхлэхээр байсан юм. Харин өөрчлөлт оруулах хуулийн төсөлд хэрэгжих хугацаағ 2017 оны долдугаар сарын 01-ний өдрөөс байхаар тусгаж өгчээ. Хууль зүйн байнгын хороо өнгөрсөн долоо хоногт хуралдаж, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төсөл /Засгийн газар наймдугаар сарын 15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/-ийг хэлэлцсэн. Энэ үед АН-ын бүлэг тав хоног завсарлага авах хүсэлт гаргасан боловч цаг хугацааны асуудалтай байгаа тул нэг хоногийн завсарлага өгсөн юм. Завсарлагын хугацаа дууссан боловч АН-ын бүлэг өнгөрсөн баасан гарагт хуралдах бүлгийн хурал дээрээ Хууль зүй дотоод хэргийн сайдын мэдээллийг сонсч байж шийдвэр гаргана гэж Хууль зүйн байнгын хорооны хуралг цуцлуулсан. Тэгвэл өчигдөр УИХ дахь АН-ын бүлэг Төрийн ордонд энэ асуудлаар хүний эрхийн байгууллагуудтай хамтран нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлгийн эхэнд бүлгийн дарга С.Эрдэнэ хуулийн дагуу Ардчилсан намын бүлэг тав хоногийн завсарлага авахыг хүссэн ч Хууль зүйн байнгын хорооны дарга өөрөө хууль зөрчин нэг хоногийн завсарлага өгсөн гэдгийг хэлээд Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогтоос ямар үндэслэлээр энэ хуулийн хэрэгжих хугацааг хойшлуулж байгааг сонссон юм. Хууль зүйн сайдын хийсэн мэдээлэлтэй холбогдуулан гишүүд асуулт асуух гэсэн боловч С.Бямбацогт хаалттай хуралдсан үед асуултад хариулах боломжтой гэсэн юм. Бүлгийн дарга С.Эрдэнэ Хууль зүйн байнгын хороо эл асуудлаар нээлттэй хуралдсан, бид хаалттай хуралдахгүй гэхэд Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт асуултад хариулахаас татгалзаж, хуралдааныг орхин гарсан юм.

### С.Бямбацогт: Эрүүгийн хуулийг зориуд хэрэгжүүлэхгүй байгаа юм биш

*/Хууль зүй, дотоод хэргийн сайд/*

-Эрүүгийн хууль болон Зөрчлийн хуулийг 2016 оны есдүгээр сарын 01-нээс дагаж мөрдөхөөр байсан. Гэхдээ хүндрэл бэрхшээл учрахаар байна. Нэгдүгээрт, дагалдах хуулиудын эцсийн найруулгыг сонсоогүй байгаа учраас дээрх хуулиудыг хэрэгжүүлэхэд бэлтгэл ажил хангагдаагүй байна. Дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 70 орчим журам, заавриг батлах ёстой. Харамсалтай нь Эрүү, Зөрчлийн хуулийг дагаж гарах таван хууль ёсчлон батлагдаагүй байгаа учраас дээрх хууль хэрэгжих боломжгүй. Хоёрдугаарт, Эрүү, Зөрчлийн хуулийн агуулга, мөн чанар, үзэл баримтлалыг олонд таниулах ажил хийгдээгүй, хуулийг хэрэгжүүлэх 40 мянган албан хаагчид сургалт хийгдээгүй, сургалт бол цаг хугацаа шаардсан ажил. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар дээр 1500 орчим орон тоо шинээр бий болж, хууль хэрэгжих боломжтой, энэ төсөв, хөрөнгө улсын төсөв дээр суугаагүй. Мөн шинээр хорих анги барьж байгуулах, өөрчлөн зохион байгуулахад 91 тэрбум төгрөг хэрэгтэй. Энэ мэт шалтгаанаас болоод Эрүү, Зөрчлийн хууль хэрэгжих боломжгүй байна. Түүнээс биш зориуд хэрэгжүүлэхгүй байгаа юм биш. Өнөөдрийн байдлаар хэрэгжих боломжгүй байгаа учраас хугацааг нь хойшлуулсан.

Ийнхүү Хууль зүй, дотоод хэргийн сайдын тайлбарыг сонссоны дараа гишүүд өөрсдийн байр суурийг илэрхийлсэн юм.

### Л.Болд: МАН–ын Засгийн газар 26 жилийн ололтоос ухрах гээд байна

*/УИХ-ын гишүүн/*

-Өнгөрсөн парламентад хийсэн хамгийн том шинэчлэлүүдийн нэг нь эрх зүйн салбарт хийгдсэн. Гэтэл МАН-ын Засгийн газар байгуулагдаад өнгөрсөн 26 жилийн ололтоос ухрах гээд байна. Үүний цаана маш олон хүний эрх зөрчигдөж байгаад бид харамсч байна. Хуулийн хэрэгжих хугацааг хойшлуулах үндэслэл нь бодитой биш. Энэ хууль хүчин төгөлдөр болоход хүн болгонд өгч байгаа ял өөрчлөгдөнө. Энэ олон шорон, хоригдол байх шаардлагагүй болно. Нэг хүнийг бүх насаар нь хүлгийч хоригдол болгох ийм тогтолцоог биш иргэн бүрийг нийгэмшүүлдэг тогтолцоог бүрдүүлэхийн тулд эдгээр хуулийг хийсэн. Дургүйд хүчгүй гэгчээр хэдхэн хуулийнхаа эцсийн найруулгыг сонсчихож чадахгүй. Асуудлыг засаад цааш нь аваад явахын оронд хойшлуулах, болиулах бодлого барьж байгаа нь харамсалтай. Энэ хуулийг олон нийтэд сурталчилгаагүй байна, хуулиа ёсчлоогүй байна гэж байна. Уг нь энэ хууль шиг сайн сурталчилгдсан хууль байхгүй. Бүх хууль дүрэм, журам бэлэн гэдгийг ажлын хэсгийнхэн хэлсэн. Ганцхан хуулиа ёсчлоод явахад л болох байсан. Өдөр болгон өөр үндэслэл гаргаж ирж байна. Үнэхээр харамсалтай байна. Одоо Ардчилсан хувьсгалаа үгүйсгээд Монгол Улсад дарангуйлал бий болгох уу. Өөрийн чинь хэлсэнчлэн олон шорон бий болгож, олон ажлын байр бий болгох шаардлага байхгүй. Энд заль хэрэглэж байгаа. Өнөө, маргааштүй хэрэгжих хуулийг хойшлуулж байгаа нь Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотой. Хууль зүйн байнгын хорооны дарга анх удаа хуралдаж байж, хууль зөрчиж байна.

### Ц.Оюунгэрэл: Хүчирхийлэлд өртдөг хүмүүсийн эрх зөрчигдөх гээд байна

*/АН-ын гишүүн/*

-Энэ хуулийн сурталчилгаа хийгээгүй тул хэрэгжих хугацааг хойшлуулна гэдэг тайлбарыг Хууль зүй, дотоод хэргийн сайд өглөө. Гэтэл өнгөрсөн парламентад байсан эмэгтэй гишүүд шаргал алчуур зүүгээд "Гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх хуультай боллоо" гэж мэдэгдэж байсан. Эдгээр хуулийг хойшлуулснаар есдүгээр сарын 01-нээс эхлээд гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг хүмүүсийн эрх зөрчигдөх гээд байна. Хүчирхийллийн дуудлага авсан цагдаа хамгийн түрүүнд тэр айлд очиж арга хэмжээ авдаг, хүүхэд хүчирхийлж байгаа мэдэгдэхгүй бол хариуцлага хүлээдэг ийм хуультай болох байсан. Гэтэл харамсалтай шалтгаанаар хойшлуулах гэж байна.

### Д.Эрдэнэбат: Засгийн газрыг огцруулах асуудлыг тавих ёстой

*/УИХ-ын гишүүн/*

-Эрүүгийн хууль болон Зөрчлийн хуулийн асуудлаар өнгөрсөн 10 жилийн сэдэв болсон. Гэнэт л одоо яригдаад эхэлсэн асуудал биш гэсэн үг. МАН-ынхан хүртэл шоронжсон улс боллоо, аль эртний ОХУ-ын эрүү шүүлтийн процессоор явж байгаа гэх мэтээр бүгд шүүмжилсэн. Тэгээд өнгөрсөн дөрвөн жил үнэхээр энэ АН-ынхан олонхи байхад энэ хуулийг зүтгүүлж байж, их ч зовлон туулж батлагдаад үндсэндээ дууссан хууль байсан. Өнөөдрийн ярьж байгааг анзаарч байхад нэг л зүйл анзаарагдаж байна. Яах вэ, АН-ын нэртэй болгоныг байхгүй болгож, үгүйсгэж болно л доо. Гэхдээ ийм увайгүй байдлаар болохгүй гэдгийг би удаа дараа хэлж байна. Төсөв зардлын асуудлаар хүний эрхтэй холбоотой эрх зүй рүү халдаж болохгүй. Үйлдвэрлэгчид, баялаг бүтээгчдийн эрх, төрийн албан хаагчдын амьдрал руу, 85 мянган иргэний орон сууц өмчлөх эрх рүү халдаж болохгүй. Харамсалтай нь өнөөдөр бүх зүйл эсрэгээрээ яваад эхэллээ. Зөвхөн төсөв, зардал, хүндрэл гэдэг нэрийн дор АН-ын хийсэн болгоныг үгүйсгэж, тэр дундаа бүр дийлэнх олонхиороо хуулийн эрх зүйн орчныг хүчээр өөрчлөнө гэдэг байж болохгүй зүйл гэж хэлээд байгаа юм. Үүнийг яасан ч зөвтгөж болохгүй зүйл. Би бүлгийн даргад нэг байр суурия хатуу илэрхийлье. Эрүүгийн болон Зөрчлийн хууль, түүнийг дагалдах таван процессын хууль бол Монгол Улсын өмнөх парламентаар батлагдсан хуулиуд гэдэгтээ АН хатуу байх ёстой. Найруулга сонсох, ёсчлох гэдэг бол зүгээр процессын асуудал шүү дээ. Хэрвээ үүнийг зөрчөөд, Засгийн газар асуудлыг оруулж ирэх юм бол АН-ын бүлэг Засгийн газрыг огцруулах саналыг өнөөдрөөс эхлээд тавих хэрэгтэй. Төсөв, зардалтай холбоотой төсвийн элдэв асуудал байж болно. Харин хүний эрхтэй холбоотой асуудлаар хууль зөрчин хүчээр түрж орох юм бол Засгийн газрыг огцруулах асуудлыг тавих ёстой. Бид яахаараа ийм хүлцэнгүй байх ёстой юм бэ. Тэр 65 гишүүн бүгд эрээ цээргүй алдчихсан, нэг конопонд орчихсон гэж би хувьдаа бодохгүй байгаа. Хүний эрхийг хамгаалагч олон гишүүн байгаа байх.

### С.Эрдэнэ: Нэмж шорон барих ямар ч шаардлага байхгүй

*/АН-ын бүлгийн дарга/*

-Эрүүгийн болон Зөрчлийн тухай хууль, түүнийг дагалдаж гарч байгаа процессын хуулиуд бол хүний эрхийг дээрдүүлэхээр баталсан. Торгох, хорих, цаазын гэсэн гурван төрлийн ял байсан бол үүнийг өөр олон хувилбар руу шилжүүлээд, хүний эрхийг дээшлүүлэх, нийгэмшүүлэх тал руу нь асуудлыг хандуулаад явахаар эдгээр хуулийг баталсан. Тэгээд ч энэ хуулийн хүрээнд нэмж шорон барих ямар ч шаардлага байхгүй. Нэмж 150 хянагч байлгах ч хэрэг байхгүй. Тиймээс 91 тэрбум төгрөг хэрэгтэй гэх тооцоо судалгаа ямар ч үндэслэлгүй. Өнөөдөр зүгээр л олон түмний тархийг угаах гэсэн хуулийг хойшлуулах шалтаг болгох гэсэн тоо. Илэн далангүй хэлэхэд МАН-ынхан шороножсон нийгмээ хэвээр нь хадгалах, хүний эрхийг ноцтой зөрчсөн хууль эрх зүйн нөхцөлөө хадгалах гэсэн оролдлого гэж харж байгаа.

Энэ удаагийн УИХ дахь АН-ын бүлгийн хурал дээр Хүний эрхийн хуульч М.Ичинноров тэргүүтэй хүний эрхийн төлөө ажилладаг хүмүүс ирж байр сууриа илэрхийлсэн. Тэд мөн л хүний эрхийг хамгаалах том алхмаас ухралт хийж байгааг шүүмжилж байв. Ийнхүү АН-ын бүлгээр хэлэлцсэн эхний асуудал дуусч, бүлгийн хурал хаалттай горимд шилжсэн юм. Харин УИХ дахь МАН-ын бүлэг өчигдөр 10:00 цагт хуралдах тов зарласан. Бага зэрэг хоцорч эхэлсэн ч бүлгийн хурлаар асуудлаа ярилцаад үдээс хойш дахин хуралдав. Ийнхүү нэг өдөр хоёр дахь удаагаа хуралдах болсон шалтгаан нь өчигдөр Хууль зүйн байнгын хороо 14:00 цагт хуралдаж, Эрүүгийн болон Зөрчлийн хууль, Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэлэлцэх болсонтой холбоотой байсан ажээ.

БАЙНГЫН ХОРОО

# ЭРҮҮГИЙН ХУУЛИЙГ ХОЙШЛУУЛАХ АСУУДЛЫГ ДЭМЖЛЭЭ

Хууль зүйн байнгын хороо өчигдөр 14.00 цагт хуралдаж Засгийн газраас өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэх эсэх, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг хэлэлцэж дэмжив. Цаг хугацаа болоод хөрөнгө мөнгөний гачигдалтай байгаа тул хуулийн хэрэгжих хугацааг хойшлуулахаас өөр аргагүй болсон гэж Хууль зүй дотоод хэргийн сайд С.Бямбацогт тайлбарлалаа. Тэрбээр "Хууль сахиулах үйл ажиллагааны тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Прокурорын байгууллагын тухай хуулийг хэлэлцэн баталсан боловч эцсийн найруулгатай танилцаж, ёсчлон батлаагүй. Иймд Эрүүгийн хууль, холбогдох бусад хуулийн хэрэгжилтийг хангах боломжгүй болсон. Учир нь дээрх хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой 70 орчим журам заавар, аргачлал загвар гэх мэт эрх зүйн дэд актуудыг Засгийн газрын гишүүн УДШ-ийн Ерөнхий шүүгч, ШЕЗ, УЕПГ-аас дангаар эсвэл хамтран батлахаар заасан. Үүнийг хийгээгүй учир одоогоор Эрүүгийн хууль боловсруулалтын шатанд байна. Хоёрдугаарт, Эрүүгийн хууль болон бусад дагалдах хуулийн хэрэгжилт, мөн чанарыг олонд сурталчилж таниулах урьдчилсан байдлаар хэрэгжүүлэхийн тулд 40 гаруй мянган албан хаагчийг сургах бэлтгэх, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авах шаардлагатай байгаа юм. Гуравдугаарт Эрүүгийн хууль болон дагалдах хуулийн хэрэгжилттэй холбоотой төсвөөс хөрөнгө оруулалт хэрэгтэй. Тухайлбал Эрүүгийн хуульд ялын төрөл хэлбэрийг шинээр тодорхойлж, зорчих эрхийг хязгаарлах, хорих ялыг доод хэмжээг долоо хоногоос эхэлж ялыг нээлттэй хаалттай эдлүүлэх зэрэг зохицуулалттай уялдуулан албан хаагчийн орон тоог нэмэгдүүлэх, хорих ангийг бүсчилсэн нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэх шаардлагатай байгаа юм. Баруун бүсэд хаалттай хорих анги байгуулахад санхүүжилт шаардлагатай байна. Иймд Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг санаачлан боловсрууллаа" гэсэн юм.

Ийнхүү Хууль зүй дотоод хэргийн сайд тайлбар хийсний дараа хуулийн байгууллагынхан Эрүүгийн хуулийг хэрэгжүүлэхэд ямар хүндрэл бэрхшээл тулгарч байгаа талаар тайлбар мэдээлэл өгсөн. Тэдний хэлж буйгаар Гэрч хохирогчийг хамгаалах хуулийг хэрэгжүүлэхийн тулд мэдүүлэг авах тусгай зориулалтын байр барих шаардлагатай, улсын хөрөнгө санхүүжилтээр хийх шаардлагатай олон ажил байна. Гэтэл хоёр хоногийн дараа уг хууль хэрэгжвэл ямар ч бэлтгэлгүй байгаагаа учирлалаа.

## Ерөнхийлөгч "Монголын нэр ертөнцийн чихнээ" сэдвээр хичээл заана

Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж жил бүрийн есдүгээр сарын 01-ний өдөр хичээл заадаг уламжлалтай. Тэрбээр энэ жил "Монголын нэр ертөнцийн чихнээ" гэсэн сэдвээр хичээл заахаар болжээ. Эргэн санулахад, Ерөнхийлөгч 2009 оны есдүгээр сарын 01-нд "Дэлхийн дулаарал-Монгол орон", 2010 онд "Монголын бахархал", 2011 онд "Монголын сайхан орноор", 2012 онд "Хүн болох багаасаа", 2013 онд "Хуулийн засаглал-хүүхдийн оролцоо", 2014 онд "Бүтээлч боловсрол-Бүтээгч иргэн, Боловсрол-Хүүхэд бүрийн төлөө", 2015 гэсэн "Саналаа зөв бол заяа зөв" гэсэн сэдвээр хичээл зааж байсан. Ерөнхийлөгчийн хичээл ирэх пүрэв гарагт буюу есдүгээр сарын 01-ний өдрийн 10.00 цагт эхэлнэ.

ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын 60 мөр

## Байр түрээслэж бизнес хийгчдээс татвар аваач

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Үүнтэй зэрэгцээд хүүхдийн 20 мянгыг зогсоох, дараа нь хүүтэй өгөх ч гэх шиг. Автомашины албан татварыг дахин нэмэх. Иргэдийн амьдарч байгаа байрнаас ам.метрээр нь тооцож татвар авах гэх мэт ард түмний халаасыг тэмтэрсэн бодлого ч гарч ирлээ. Уг нь тухайн иргэн ганц орон сууцтай байгаад, тэр нь хэдэн ч ам.метр байсан ядаг юм. 150-аас дээш ам.метртэй байранд амьдарч байгаа дундаж амьдралтай иргэн өчнөөн л байгаа шүү дээ. Тэд бага зэрэг том талбайтай, 3-4 өрөө орон сууцанд амьдарснаараа төрд ямар гай болчихоов. Энэ мэт буруу шийдвэрүүдээ харж үзэх л хэрэгтэй. Харин татвар авах гээд байгаа бол бүх хүнийг хамруулах хэрэгтэй. Зөвхөн ажил хийж, цалингаас цалингийн хооронд амьдарч байгаа иргэдийнхээ голыг харлуулахын оронд шүү дээ. Тухайлбал, Улаанбаатар хотод зөвхөн орон сууц түрээслүүлээд, асар их ашиг олж байгаа хүн олон байгаа. Хувьдаа 10, 20, цаашлаад 50 байртай хүн хүртэл байна гэсэн too яваад л байсан. Бүр статистик бүртгэлээр 10, 20 байртай гэдэг нь тогтоогдчихсон, АТГ шалгаад байсан шүү дээ. Тэр хүмүүс олон байраа сардаа багадаа л 400 мянган төгрөгөөр түрээслэж байгаа. Цаашлаад өрөөний тоо, талбай нь томорч, хотын төвдөө ойртох тусам илүү үнэтэй болдог. 10 байртай, түүнийгээ түрээсэлдэг хүн сард хамгийн багадаа дөрвөн сая төгрөг элбэг олчихно. Гол нь түүнээсээ татвар төлж байгаа бил үү. Өнөөдөр орон сууцны үнэ буурахгүй, хөөсөрсөн чигтэй байна. Орон сууцны компаниуд байрныхаа үнийг буулгахгүй гүрийгээд байгаагийн нэг нөлөө нь энэ ч байж болно. Олон байртай хүмүүс түрээсэлж олсон мөнгөө хэдхэн сар цуглуулаад л дахиад нэгийг авчихна. Бүр олон байр түрээсэлдэг бол ганц, хоёрхон сар болоод л нэгийг худалдаж аваад байх боломжтой шүү дээ. Тийм болохоор энэ төрлийн бизнес эрхэлж байгаа нөхдүүдийн халаас руу гар дүрэх цаг аль хэдийнэ болсон. Зөвхөн ажил хийж, сардаа 500-800 мянган төгрөгийн цалин авч байгаа иргэдээсээ хүн амын орлогын албан татвар гэж аваад байдаг. Тэр нь 10 хувь. Гэтэл сардаа хэдэн саяын цалинтай хүнээс ч адилхан 10 хувийн татвар авдаг. Бүр олон байр түрээслээд, хэдэн арван саяар нь ашиг олж байгаа хүмүүсээс татвар авч ч чадахгүй тийм л тогтолцоо Монголд байна. Уг нь 500 мянган төгрөгийн цалинтай хүнээс тав, сая давсан цалинтай бол 10. 2, 3 сая төгрөгийн орлоготой бол 15 хувь гээд арай өөр системээр авдаг тогтолцоотой болох цаг болсон л байлтай. Гэвч тэд чаддагаараа нь бидний л халаас руу гар дүрчих гээд чичрээд байна. Уг нь хувьдаа гурваас дээш орон сууцтай бол дөрөв дэхээс нь тэдэн хувийн татвар авна гээд л хуульчлаад өгчихөд болмоор санагдах юм. Тэгэхээр нь өөрсдийнхөө бизнес рүү гар дүрэх болчихоод хэцүү байдаг юм байлгүй дээ.

# 3-ХАН САЯ ХҮНИЙГ ЯДУУ АМЬДРУУЛЖ БАЙЖ БАС БАЙГАЛИЙН БАЯЛГАА ХАРАМЛАХ УУ

Н.ПУНЦАГБОЛД

Монгол Улсын эдийн засаг элгээр мөлхлөө, хэзээ мөдгүй "амь тавих" нь. Өвчнөөр ярьвал хорт хавдрын дөрөвдүгээр шат руугаа орох гээд байна. Одоо л мэс засал хийх хэрэгтэй гэх айхтар үгийг бид сүүлийн сар гаруйн хугацаанд хангалттай сонслоо. Мэс засал хийх гээд байгаа нөхдүүд нь одоогийн эрх баригчид. Гэхдээ энд намчирхах гэсэн юм биш. Аль ч нам, хүчин нь засгийн эрх авсан ч ийм байдалтай тулж, мэс засал байна уу, эмчилгээ байна уу хийх л байсан. Харин арга нь өөр өөр байх. Одоо бол МАН-ынхан



бүх зүйлийг хэмнэх бодлого барьж эхэллээ. Зөв өө, зөв. Тэр дундаа хэтэрхий их баяжчихсан, автобусны мөнгөний үнэ цэнийг мэдэхгүй. Сарын цалингаар яаж амьдарч чадаж байгаагийн нууцыг хэчнээн тайлбарлаад ч ойлгохгүй баячууд, дээдсүүд, тансаглалдаа умбачихсан нөхдүүдийн бүсийг нь чангалаад, бэлхүүсийг нь нарийсгах хэрэгтэй. Гэвч хэмнэх бодлого тийм байж чадахгүй нь. Яах аргагүй ард иргэдийн халаас руу гар дүрээд л байна, эрх баригчид. Түүгээр ч зогсохгүй самар, жимсээ түүж, амьдралаа залгуулж, өрнөөсөө ч болов гарах гэж зүтгэж байгаа иргэдээ боомилж, дарамталж, дарлаж байна. Өнөөдөр "Самарчидтай тэмцэнэ" гэх сүржин уриа гараад ирчихэж. Хаа сайгүй дарга нар "Самар түүхийг хатуу хорь. Болц нь гүйцэхээс өмнө битгий оруул" гэж ирээд л хангинаж байна. Хэрвээ хууль бусаар самар түүвэл сая төгрөгөөр торгоно ч гэж байх шиг. Бүр сүүлдээ дөрвөн кг-аас дээш самар түүсэн иргэнийг 3-6 сар хорино ч гэж байх шиг. Эсвэл цагдаа нар тэр ч уулын ам руу явж, самарчдыг буулгалаа. Төчнөөн кг самар хураалаа гэж мэдээлээд л. Монголын төр үнэхээр иргэдээ дарлаж чаддаг юм байна. Байгалиа хамгаалдаг болчихож, ямар бахархмаар юм бэ. Нэгэнт очоод түүчихсэн хэдэн кг самрыг нь дарамталж, хууль журам ярьж хурааж авчихаад, түүнийгээ байгаль хамгаалсан болгож сүржигнүүлж байгаа чинь ариун явдал уу. Гэтэл цаана чинь алтны компаниуд байгалийг яаж сүйтгэж байна. Орхон гол улаанаараа урсч байгаагийн буруутанд яагаад төрийн "төмөр нүүр" үйлчлэхгүй байна. Ажлын хэсэг байгууллаа, очиж шалгалаа, алдаа дутагдлаа засахгүй бол тусгай зөвшөөрлийг чинь хураана гэж хэлчихээд ирлээ л гэдэг. Ингэж л эрхлүүлж байна. Гэтэл ууланд гараад, ядарсан иргэдийн нэгэнт түүчихсэн самрыг нь шууд хураагаад авчихдаг. Энэ удаа явууллаа, дараа ингэж журам зөрчвөл самрыг чинь хураана гэсэн сануулга энгийн иргэдэд хэт зөөлдөх юм байна л даа. Монголын төр өнөөдөр гуравхан сая иргэнээ сайхан амьдруулж чадаж байгаа бил үү. Сайхан амьдрах нөхцлийг нь бүрдүүлсэн үү. Хоорондоо уралцаж, эрх мэдлээ булаалдаж, ярдаг нохой шиг хэмлэлдэж, төсвийн мөнгийг хувьдаа завшиж, эдийн засгийг элгээр нь мөлхүүлсэн. Ард түмнийг хэчнээн жил тэжээх боломжтой том том ордууд байж л байна. Гадаадынханд тавьж туугаад, өөрсдөө хувь хүртээд л дууссан. Тэгээд монголчууд ажилгүй, арчаагүй гэж дуудаж тавлаад л. Өнөөдөр өгч байсан хэдэн төгрөг, хүүхдийн 20 мянгаа ч харамлаж эхэлсэн. Тийм байж байгальд байгаа самар, жимсхэн түүгээд, амьдралаа болгох гэж зүтгэж байгаа ард иргэддээ хатуу хандчихалгүй, аятайхан бодлого яагаад гаргачихаж, зохицуулчихаж чаддаггүй юм бэ. Ямар та нараас мөнгө өгөөч гэж гуйсан биш дээ. Ингэснээрээ хууль, журам зөрчиж, байгаль орчноо сүйдэлж, дураараа дургих ёстой гэж байгаа юм биш шүү. Нөгөө "Найрах арга чинь буруудаад байна" гэдэг шиг самарчид гэж харлуулаад байгаа ядарсан иргэдтэй тэмцэх арга чинь буруу байна. Өнөөдөр Монголын хушин ойн нөөц бага гэдгийг мэднэ. Самар боловсорч дуусаагүй, гүйцэд болоогүй байхад түүх нь байгаль орчинд сөрөг нөлөөтэйг ч хэн хүнгүй л мэдэж байгаа. Дээрээс нь самар, жимс түүж байгаад гал алдаж, түймэр гарах нөхцөл ч нэмэгддэг. Ядаж л самар түүх гэж байгаа хүмүүс наймдугаар сард биш есдүгээр сарын дундуур "ажил"-даа гардаг бол дээр шүү дээ. Мөн самар түүж яваад, модон дээрээс унаж амиа алдаж байгаа хүний тоо ихсэх шинжтэй. Гэх мэтээр асуудал бий бий, үнэн. Гэхдээ энэ бүхнийг худлаа хорьсон дүр үзүүлснээр, цагдаа нар нь иргэдийн түүсэн самрыг хураасныаар алга болчихно гэвэл түүн шиг үлгэр байхгүй. Самар түүхийг хориглоно гээд л байдаг. Гэтэл наймдугаар сарын дунд хүрэв үү үгүй юу Улаанбаатар хотын гудамжинд самар зараад эхэлдэг биз дээ. Цаашлаад ченжүүд нь энд тэнд мэр сэр самар худалдаж аваад байдаг. Гэтэл тэдэнтэй хэн тэмцэж байгаа юм. Зүгээр л заруулаад байгаа биз дээ. Ийм байхад хүмүүс уул руу явж, самар түүхгүй гээд яах юм. 10, 20 кг самар түүж ирээд, шилэн аягалаад зарчихад 30, 40, цаашлаад 50 мянган төгрөг олчихно. Эсвэл кг-ийг нь 2-3 мянган төгрөгөөр зарчихвал шуудай гурил, хэдэн кг махны мөнгөтэй болчих л байх. Ийм байхад хүмүүс уул руу дайрахгүй гээд яах юм. Хотын төвд зарж байгааг нь хорихгүй, уул руу явж байгааг нь хорьсон маягтай байхаар яаж бүтэх вэ дээ. Ам болгон дээр цагдаа зогсоогоод ч хэрэг байхгүй. Зарим байгаль хамгаалагч, байцаагч нь хэдгурван төгрөг аваад л хүн оруулчихаж байгаа. Түүний оронд хэзээ самар худалдаж авч эхлэх хугацаагаар нь зохицуулж өгмөөр байна. Мөн гудамжинд зарахыг хатуухан хорьчихооч. Тэгвэл самар түүж байгаа иргэдийн ууланд гарах хугацааг наймдугаар сард биш есдүгээр сард болох магадлалтай. Өөр ямар арга байна, тэр бүхнийг хэрэгжүүлэх хэрэгтэй. Түүнээс биш баахан цагдаа гаргаж, уулын аман дээр зогсоочихоод, иргэдийг дарамтлаад байвал бүтэхгүй. Саяхан Өвөрхангай аймгийн Хужирт суманд самар түүлгэхгүй гэж хорьж, иргэдийг дарамталж, түүсэн самрыг нь хурааж байсан цагдаа нарыг зодож, уул руу дайрсан байна билээ. Тиймээс Хужирт, Бат-Өлзий сумын удирдлагууд иргэдийг самар түүхийг хориглохгүй ууланд гаргаж эхэлж. Нэгэнт хориод дийлэхгүй бол одоо байгаль хамгаалагчид нь яваад, иргэддээ зөвлөгөө өгөөд, гал алдахаас сэргийлээрэй гээд л ажиллах хэрэгтэй байх. Өнөөдөр иргэдийн амьдрал ямар байгаа билээ. Хүнд л байгаа шүү дээ. Ядаж байхад жил бүр оюутны сургалтын төлбөр нэмэгдэж байна. Банкны зээлийн хүү хэд билээ. Иргэд арай л гэж амь амьдралаа залгуулж байна. Дээрээс нь Засгийн газрынхан нь хасна, танана, хэмнэнэ, бүсийг чинь чангална, та нар тансаг байдалд автаад байна гээд дайраад л байгаа. Ийм үед иргэдээс самар, жимсхэн харамлаад, дарамтлаад байвал цагдааг битгий хэл зодох байлгүй, ард түмэн. Ядаж байхад Япон-Монголын хамтарсан эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн дагуу манай улс арлын орон руу 9300 нэр төрлийн бүтээгдэхүүнийг татваргүй гаргах нөхцөл бүрдээд буй. Тэр дунд хуш модны самар багтсан. Тиймдээ ч есдүгээр сарын 15-наас хойш самрын ханш тогтож, өмнөх жилүүдийнхээс илүү үнэд хүрнэ гэсэн цуурхал гарчихсан. Аль хэдийнэ энэ яриа газар авчихсан, барьж тогтоохоосоо өнгөрсөн. Тэгээд Япон руу гарах барааны жагсаалтад самар багтсан болохоор зах зээлтэй болчихлоо. Одоо хятадууд ч өндөр үнээр авч эхэлнэ гэсэн яриа байна. Ийм байхад ард иргэдийг хорино, торгоно, самрыг нь хураана гээд юунд хүрэх билээ. Эцэстээ самарнаас болж зодоон цохион, бослого тэмцэлдээ ч хүрч эхэллээ. Ингэж муйхарлаж байхын оронд арай эвтэйхэн бодлого бариач. Ченжүүд нь самрын болц гүйцсэн үеэс эхлээд боломжийн үнээр авдаг, тэр болтол ухуулга сурталчилгаа хийх замаар иргэддээ ойлгуулах гэж үздэг болмоор байна. Хэтэрхий хориод, цагдаад, хууль сахиулж байгаа нөхдүүд нь зүгээр сууж байгаад хэн нэгэн иргэний түүсэн самрыг хурааж авч, магадгүй цааш нь өөрөө зараад байдаг бол ямар нэмэр байна. Уг нь бид байгалийн баялаг, самар, жимсээ гадагш нь гаргаад, мөнгө төгрөг олоод, ард түмний амьдрал дээшилж л байвал сайнсан. Гэтэл самар түүх нэрийдлээр байгальд хохирол учруулж байгаа гэсэн шалтгаанаар хилээр гаргахыг хориглочихсон. Гэтэл хориглолоо гээд самар түүхээ больсон бил үү, хүмүүс. Хятадууд авахаа зогссон уу. Харин ч хориглосон барааг бид энэ зэргийн үнээр авч байгаа нь их юм гэсэн байдлаар хандаж, үнийг нь унагаж л байгаа байх. Яг хөрсөн дээр иймэрхүү л юм болж байна даа, эрх баригчид минь. Дашрамд дурьдахад, газар дор байгаа шавхагддаг баялгаа дуусгаж байхаар газар дээрх шавхагддаггүй баялгаа мөнгө болгоё л доо.

> ...Ингэж муйхарлаж байхын оронд арай эвтэйхэн бодлого бариач. Ченжүүд нь самрын болц гүйцсэн үеэс эхлээд боломжийн үнээр авдаг, тэр болтол ухуулга сурталчилгаа хийх замаар иргэддээ ойлгуулах гэж үздэг болмоор байна. Хэтэрхий хориод, цагдаад, хууль сахиулж байгаа нөхдүүд нь зүгээр сууж байгаад хэн нэгэн иргэний түүсэн самрыг хурааж авч, магадгүй цааш нь өөрөө зараад байдаг бол ямар нэмэр байна...


## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2016-08-29**

Тендер шалгаруулалтын нэр: **Баян-Өндөрийн гудамжийг Хантайн гудамжтай холбох автозам /Б хэсэг 0.828 км/**

Тендер шалгаруулалтын дугаар: **ОР-185/2016**

**Орхон аймгийн засаг даргын тамгын газар** нь эрх бүхий тендерт оролцогчдоос **Баян-Өндөрийн гудамжийг Хантайн гудамжтай холбох автозам /Б хэсэг 0.828 км/ ажил**–ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь **50,000 /тавин мянган/** төгрөгөөр худалдан авч болно.

Тендерийн баримт бичгийн үнийг доорхи дансаар тушаана.

Төрийн сан

Дансны дугаар: 210051009

Хүлээн авагч: Орхон аймгийн ХАА-ны алба

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Тусгай зөвшөөрөл: Хатуу хучилттай авто зам барих тусгай зөвшөөрөлтэй байх

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил (2014, 2015 он)

Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх

Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн **[1%]** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2016 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 09 цаг 00 минутаас** өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2016 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 10 цаг 00 минутанд** нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Орхон аймгийн ЗДТГ, Нутгийн удирдлагын ордон**
**1 давхар 113 тоот өрөө Утас:70358570**



## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2016-08-29**

Тендер шалгаруулалтын нэр: **"ЭУДТС" ОНӨХК-с Баян худалдааны төвийн уулзвар хүртэлхи авто замын засвар, шинэчлэлт**

Тендер шалгаруулалтын дугаар: **ОР-186/2016**

**Орхон аймгийн засаг даргын тамгын газар** нь эрх бүхий тендерт оролцогчдоос **"ЭУДТС" ОНӨХК-с Баян худалдааны төвийн уулзвар хүртэлхи авто замын засвар, шинэчлэлт ажил**–ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь **50,000 /тавин мянган/** төгрөгөөр худалдан авч болно.

Тендерийн баримт бичгийн үнийг доорхи дансаар тушаана.

Төрийн сан

Дансны дугаар: 210051009

Хүлээн авагч: Орхон аймгийн ХАА-ны алба

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Тусгай зөвшөөрөл: Хатуу хучилттай авто зам барих тусгай зөвшөөрөлтэй байх

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил (2014, 2015 он)

Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх

Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн [1%] төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2016 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 09 цаг 00 минутаас** өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2016 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 10 цаг 00 минутанд** нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Орхон аймгийн ЗДТГ, Нутгийн удирдлагын ордон**
**1 давхар 113 тоот өрөө Утас:70358570**

УЛС ТӨР

УЛСТӨРЧ ЯРЬЖ БАЙНА



**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

-Би залуучуудтай, шинэ үеийнхэнтэй санал нэг байгаа. АН-д агуулгын шинэчлэл хийх ёстой. Өөрөөр хэлбэл, хэлбэрийн төдий бус суурь шинэчлэл хийх учиртай. Энэ тал руугаа явцгаана гэдгийг дэмжиж байгаа.

**-АН-ынхан яагаад ялагдлын дараа шинэчлэл хийх болов. Өмнө нь энэ шинэчлэлийг хийж болоогүй юм уу?**

-Угаасаа хүний араншин. Ялсан нам буюу эрх мэдэлтэй хүн хэзээ ч бодит өөрчлөлт, шинэчлэлт хийж чаддаггүй. Өөрийнхөө алдааг олж ын төлөө бид явна. Ер нь фракцийн хэдэн дарга нар л фракцитай байхыг хүсч байгаа. Түүнээс намын жирийн гишүүд, дэмжигчид бол бүгд фракцигүй намын төлөө байгаа гэдгийг би маш сайн мэдэж байна. Учир нь иргэд олон түмэнтэй уулзах болгонд фракцийн асуудлыг цэгцлэхийг, явцуу эрх ашгийн фракцийг татан буулгаж, мэргэжлийн бодлогын зөвлөл рүү шилжихийг шаарддаг.

**-ҮЗХ-ны хурал хойшилчихлоо. Энэ удаагийн хурлаар ямар асуудлыг хэлэлцэх юм бол?**

-Миний бодлоор энэ ҮЗХ бол яг АН-ын зөвлөлдөх хороо биш. Энэ бол нэг фракцийн давамгайлсан байна. Үүн дотор таны нэр яригдаад байгаа?

-Нэг зүйлийг би хэлье. Намын дарга хэн болох вэ гэж бодохоосоо илүүтэй намын дүрэм, журмаа яаж шинэчлэх вэ гэдэгт санаагаа чилээх хэрэгтэй байна. Батзанданг намын дарга болчих вий гэж нойргүй хоножбайгаа хүмүүст хандаж нэг л зүйл хэлнэ. Намын шинэчлэлийн төлөө бүгдээрээ нэгдэх хэрэгтэй. Батзандан намын дарга болох, болохгүй нь номер нэг асуудал биш. Тийм ч чухал асуудал биш шүү дээ. Болж ч болно, болохгүй ч байж болно. Намын эрх ашиг, улсын эрх ашиг нэгдүгээрт тавигдана. Өөрөөр хэлбэл, Батзандангийн эрх ашиг намын шинэчлэлийн хэрэггүй. Ганцхан Монгол Улсын эдийн засаг хүндрээд байгаа юм биш. Дэлхийн эдийн засаг маш хүнд байгаа. Эдийн засгийн хямралаас гаргана, улс орныг дампуурлаас гаргана гэж амлаж, сонгуульд оролцсон. Үүнд итгэсэн иргэд, сонгогчид МАН-д саналаа өгсөн. Тиймээс одоо ажлаа хийх хэрэгтэй. Монгол Улсын эдийн засаг сүүлийн он жилүүдэд дэлхийн эдийн засгийн хямралаас шалтгаалж, хүндэрсэн тал бий. Түүнчлэн бодлогын зарим нэгэн алдаа гарсан тал бий. Харин үүнийг засч залруулах эрх нь МАН-ынханд байна. Засч, залруулна гэж төрийн эрх мэдлийг авсан. Тиймээс ажлаа хийх хэрэгтэй л гэж

# Ж.БАТЗАНДАН: НАМАЙГ НАМЫН ДАРГА БОЛЧИХ ВИЙ ГЭЖ НОЙРГҮЙ ХОНОЖ БАЙГАА ХҮМҮҮСТ НЭГ Л ЗҮЙЛ ХЭЛНЭ

хардаггүй. Энэ бол хүний бач. Харин ялагдсан нам, ядарсан хүн хоёр илүү ухаантай байдаг. Ялагдлын дараа амьдралаа эргэцүүлж боддог. Алдаа, оноогоо тунгааж, харах боломжтой болдог. Тэгвэл АН 2016 оны УИХ-ын сонгуульд ялагдсан учир өнөөдөр шинэчлэлийн тухай ярьж байна.

**-АН ялагдаад одоо л ухаан сууж, шинэчлэл яриад эхэллээ гэлээ. Угаасаа энэ ялагдал хэрэгтэй зүйл байсан юм биш үү?**

-Угаасаа шинэчлэлийн тухай ярих ёстой. Ялагдсан учир шинэчлэгдэж, өөрчлөгдөх учиртай. Хэрвээ АН одоо л шинэчлэгдэхгүй юм бол дахин хэзээ ч сонгуульд ялахгүй. Тэгээд ч одоо өөрчлөлтийг хийж чадахгүй бол улс төрийн тавцангаас арчигдана. Энэ бол маш тодорхой харагдаж байгаа.

**-Намын ахмад гишүүд ч тэр, залуу гишүүд ч АН фракциудын хагарлаас болоод ялагдсан гэх юм. АН одоо хийх шинэчлэлээрээ фракцигүй улс төр рүү орж чадах болов уу?**

-Фракцигүй улс төр рүү орох ёстой. Фракцигүй, хуваагдалгүй. нэгдмэл АН-ҮЗХ. Маш тодорхой хэлбэл Н.Алтанхуягийн ҮЗХ юм. Өөрөөр хэлбэл, одоо хуралдах гэж байгаа ҮЗХ бол АН-ын зөвлөлдөх хороо биш Алтанхуягийн зөвлөлдөх хороо.

**-Яагаад?**

-АН 2012 оныг хүртэл ҮЗХ-той байсан. Тэр ҮЗХ бол шинэчлэгддэг, жил бүр салхи ордог хороо байсан. Харин 2012 онд ҮЗХ-д шинэчлэл хийх буюу шинэ гишүүд оруулахыг дүрмээр хаасан. Тэр цагаас хойш АН дампуурч эхэлсэн. Нам нэг хүний гарт орсон. Шуудхан хэлэхэд Н.Алтанхуягийн гарт орсон юм. Тиймээс одоо хуралдах Н.Алтанхуягийн ҮЗХ АН-ыг шинэчилж чадна гэдэгт би итгэхгүй байгаа. ҮЗХ-ны гишүүдийн 65 хувь нь Алтанхуягийн хүмүүс байдаг. Өөрөөр хэлбэл, түүний ах, дүү, хамаатан садан, найз, нөхдүүд байгаа. Алтанхуягийн ах, дүү, хамаатан садан Монголыг ардчиллыг аварч чадна гэдэгт би итгэхгүй байна. Тиймээс энэ ҮЗХ-г татан буулгаж, намын их хурлаар намын шинэчлэлийн асуудлыг цогцоор нь авч үзэх нь зүйтэй гэсэн байр суурьтай байгаа.

**-Намын даргын марафонд хэд хэдэн хүн яригдаж** дэргэд өчүүхэн эрх ашиг. Би намын дарга болох албагүй. Би намын шинэчлэлийн төлөө явж байгаа болохоос биш намын дарга болохын төлөө яваагүй гэдгээ тодорхой хэлмээр байна.

**-Таны хэлж байгаагаар ҮЗХ-ны хурлаас их зүйл хүлээх хэрэггүй. Харин намын их хурлаас нэлээд үр дүн гарах юм байна, тийм үү?**

-Бид намын их хурлаа өргөн бүрэлдэхүүнтэй хуралдуулах хэрэгтэй. Энэ удаагийн хурлаар намын шинэчлэлийн хөтөлбөрийг батлах шаардлагатай. Одоо АН-ын ҮЗХ, хяналтын ерөнхий хороо, дүрмийн хороо гээд шат шатны байгууллагууд бүгд татан буугдах хэрэгтэй. Учир нь АН нэг бизнес бүлэглэлийн нам болсон. Тиймээс одоо их цэвэрлэгээ хийх цаг нь болсон. Манай намын гишүүд ухамсартай байх цаг үе ирээд байна.

**-Эрх барьж буй МАН өртэй, санхүүгийн хүнд нөхцөл байдалтай улс орныг танай намаас хүлээн авлаа хэмээж буй. Улс орны байдал үнэхээр тийм хүнд байгаа юм уу?**

-МАН-ынхан гоншигонох хэлмээр байна. Одоо хойшоо биш. Урагшаа харж ажиллах шаардлагатай.

**-Төв банк саяхан бодлогын хүүгээ нэмчихлээ. Энэ зөв гарц мөн үү?**

-Төв банкинд бодлогын хүүг нэмэх, бууруулах эрх нь байгаа. Монгол Улсад санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл гэж бий. Энэ байгууллага макро эдийн засгийг мөнгөний бодлогоор удирдах үүрэгтэй. Монгол төгрөгийн ханш огцом унаж байгаа. Тиймээс бодлогын хүүг нэмэгдүүлэх боломж бүхий энэ алхмыг хийсэн. Буруутгах арга байхгүй.

**-Хямралыг даван туулахын тулд бараг бүх зүйлийг хасч, танаж байна. Энэ байдлаараа ойрын хугацаанд эдийн засаг сэргэх магадлал байгаа юу ?**

-Засгийн газар ямар бодлого хэрэгжүүлэхээс бүх зүйл хамаарна. Засгийн газар хөрөнгө оруулалтыг танах, дотоодын эдийн засгийн эрчимжүүлэх зөв бодлого хэрэгжүүлж чадвал Монголын эдийн засаг амархан сэргэнэ. Учир нь Монголын эдийн засаг жижиг эдийн засаг. Импортыг хоёр тэмбум долларт хүргээд, дотоодын эдийн засгийн идэвхжлийг сайжруулчихсан байхад л Монголын эдийн засаг болоод хувийн хэвшил маш хурдан хөл дээрээ босно. Би Монгол Улсын Ерөнхий сайдтай уулзсан. Өнөөдөр Монголын бүх аж ахуйн нэгжүүд иргэд өрийн сүлжээнд орсон. Тиймээс өрийн хямрал ганцхан төрийн хямрал биш. Нийгмийн хямрал болж даамжирч байна. Тиймээс Засгийн газар нэгдүгээрт хийх ажил бол иргэд, аж ахуйн нэгжүүдээ өрийн хямралаас гаргах явдал юм. Тиймээс энэ чиглэлд дорвитой бодлого явуулах чиглэлийг хэлсэн.

**-Та сая Баянзүрх дүүргийн цэцэрлэгийн удирдлагуудын төлөөлөлтэй уулзсан байсан. Сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ маш муу байна гээд яамд дээр цэцэрлэг байгуулаад эхэллээ. Энэ зөв алхам байж чадах уу?**

-Төрийн байгууллага дээр цэцэрлэг, сургууль байгуулахыг аргаа ядсан арга л гэж харж байгаа. Асуудлыг шийдэх сайн арга биш. Ард түмний хүүхдүүдийг яамны цэцэрлэгт явдаг, жирийн цэцэрлэгт явдаг гэж ялгаж болохгүй. Засгийн газарт эрх нь байгаа. Хүүхэд харах үйлчилгээний цэгүүд, түрээсийн цэцэрлэгүүдийг ажиллуулах замаар цэцэрлэгийн асуудлыг шийдэх бүрэн боломжтой. Тиймээс байгууллага хууль зүйн орчиндоо тааруулж, сургууль, цэцэрлэгийн асуудал дээр онцгойлон анхаарах хэрэгтэй. Миний бие хэд хоногийн өмнө Баянзүрх дүүргийн цэцэрлэгийн багш, эрхлэгч болон нийслэлийн боловсролын асуудал хариуцсан хүмүүстэй уулзсан. Сүүлийн жилүүдэд намар бүр цэцэрлэг, сургуулийн асуудал бухимдал дагуулдаг. Тиймээс энэ асуудлыг бодлогоор нь буюу цогцоор нь шийдэх учиртай. Тухайлбал, өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд Баянзүрх дүүрэг дээр 15 цэцэрлэг шинээр барьсан. Гэсэн хэдий ч цаана нь нийт хүүхдийн 40 хувь нь цэцэрлэггүй л байна. Энэ нь цэцэрлэгийн асуудлыг шийдэх өнөөгийн бидний арга барил буруу байгаагийн шинж. Тэгэхээр цэцэрлэгийн асуудлыг шийдэх олон аргачлал бий. Хувийн цэцэрлэгүүдийг дэмжих, хувийн болон төрийн хамтарсан цэцэрлэгүүдийг дэмжих, хүүхэд харах үйлчилгээний цэгүүд болон түрээсийн цэцэрлэгүүдийг ажиллуулах гээд олон арга байна. Харин яамны дэргэд цэцэрлэг байгуулах бол хамгийн сүүлчийн буюу хамгийн муу арга.

МЭДЭЭЛЭЛ

# АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН СТАНДАРТЫН ШААРДЛАГА ХАНГАЖ БУЙ ЭСЭХЭД ХАМТАРСАН ШАЛГАЛТ ХИЙНЭ

Автотээврийн үндэсний төв, Замын цагдаагийн газартай хамтран автотээврийн хэрэгслийн стандартын шаардлага хангаж буй эсэхийг шалгах хамтарсан шалгалтыг улсын хэмжээнд 2016 оны наймдугаар сарын 29-нөөс есдүгээр сарын 30-ны өдрийг дуустал зохион байгуулж байна.

Автотээврийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, Автотээврийн хэрэгсэлд тавих техникийн ерөнхий шаардлага MNS 4598:2011 стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор улсын хэмжээнд замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслүүдийг техникийн хяналтын үзлэгт хамрагдсан байдал, техникийн бүрэн бүтэн байдал, өнгө үзэмж, гэрэлтүүлэх хэрэгсэл, дагалдах хэрэгсэл, иж бүрдэл хангагдсан эсэхийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгуулах болно.



**Шалгах чиглэл:**

1. Автотээврийн техникийн хяналтын үзлэгт хамрагдсан байдал
2. Ашиглахыг хориглосон гэмтэлтэй тээврийн хэрэгсэл эсэх
3. Ачаа тээвэрлэх журмын хэрэгжилт, ялангуяа ачааны автомашины бүтээлэг, зуурмаг тээвэрлэгч автомашины тосгуурын бүрэн бүтэн байдал
4. Автотээврийн хэрэгслийн бүх жин ба уртын зөвшөөрөгдөх дээд хэмжээг заасан хэмжээнээс хэтэрсэн эсэх
5. Замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийн гадна хэсэг их хэмжээгээр эвдэрсэн буюу өнгө үзэм илт муудсан, салхины шил хагарсан, улсын дугаар бүдгэрч арилсан эсэх
6. Бензин хөдөлгүүртэй автомашин- Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн эсэх
7. Автотээврийн хэрэгсэлд тавих техникийн ерөнхий шаардлагын дагу гэрэл ойлгогч наалт наасан байдал




АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ


# ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**2016 оны 08 дугаар сарын 30-ны өдөр**

**Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар, Худалдан авах ажиллагааны алба** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Налайх дүүргийн 2 цэцэрлэгийн 8 бүлэг болон 140 дүгээр цэцэрлэгийн гэр бүлгийн тоглоом** нийлүүлэх үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал авах баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **50.000 /тавин мянга/** төгрөгөөр худалдан авч болно.

Төлбөрийг Төрийн сан банк- 200455009 тоот дансанд тушаана.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Үнийн санал ирүүлэх техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2016 оны 09 дугаар сарын 06-ны өдрийн 10 цаг 00 минут-аас** өмнө доорх хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2016 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 10 цаг 30 минутанд** нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх: Тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 2-р хороо,**
**Хуульчдын гудамж, ОНӨААТҮГ байр,**
**Худалдан авах ажиллагааны алба. Утас:7023-2788**
**www.nalaikh-tender.mn**

## ОНЦЛОХ ХУУДАС

# ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙГ ЗОГСООХ НЬ ЗӨВ, БУРУУ

## Эсрэг тэсрэг байр суурь



### Б.Түвшинтөгс: Орон сууцны найман хувийн зээлийг шууд зогсооно гэсэн ойлголт байхгүй

*/МУИС-ийн ЭЗС-ийн Эдийн засгийн судалгаа эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал/*

...Өмнө байсан хямралуудтай харьцуулахад, бидэнд ипотекийн зээл гэдэг шинэ суваг бий болсон. Тэр нь өөртөө мөн эрсдэлийн сувгийг бий болгоод байна.Үүнийг бид сайн анхаарах ёстой...

-Өмнө байсан хямралуудтай харьцуулахад, бидэнд ипотекийн зээл гэдэг шинэ суваг бий болсон. Тэр нь өөртөө мөн эрсдэлийн сувгийг бий болгоод байна.Үүнийг бид сайн анхаарах ёстой. Хуулиар баталсан асуудлыг шууд зогсооно гэж байхгүй. Хууль журмынхаа дагуу Монголбанк үүнийг МИК рүү шилжүүлэх журмаар ажиллах ёстой. Буцаад Монголбанкинд ипотекийн зээл нь төлөгдөх ёстой. Түүнээс биш хууль журмынхаа хүрээнд аль хэдийнэ тодорхой болчихсон асуудал учраас шууд орон сууцны найман хувийн зээлийг шууд зогсооно гэсэн ойлголт байхгүй гэж үзэж байна.



### Б.Мөнхзаяа: Эдийн засгийн нөхцөл байдал сайжрах хүртэл ипотекийн зээлийг хязгаарлах хэрэгтэй

*/Санхүү эдийн засгийн дээд сургуулийн Санхүүгийн тэнхимийн эрхлэгч/*

...Хүмүүсийн хөрөнгийг хааш нь чиглүүлэх вэ гэдэг урсгалыг зохицуулахын тулд ипотекийн зээлийг тодорхой хэмжээнд хязгаарлах хэрэгтэй л гэж боддог. Одоогоор төвлөрөл ихтэй нэлээд хэмжээгээр олгочихсон шүү дээ. Тиймээс нэмж олгох шаардлагагүй гэж бодож байна...

-Ипотекийн зээлийн төвлөрөл маш их байна. Эдийн засаг эргэлдэж байхын тулд үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбаруудаа дэмжсэн хөрөнгө оруулалт байх хэрэгтэй. Гэтэл энэ бүхэн зогсонги байдалд орчихсон. Нөгөө талаасаа эдгээр бизнес явж байгаа тохиолдолд иргэд худалдаж авах мөнгөтэй байх ёстой. Харин одоо бол хүмүүс бүх хэрэглээгээ хумьчихсан. Инфляци өсөхгүй байгаагийн шалтгааныг хүмүүс хэрэглээгээ илт багасгасантай холбоотой. Цалингаа авлаа, мөнгөөрөө орон сууцны зээлээ төлдөг. Өөр зүйл худалдаж авч идэж, ууж, өмсч зүүж, эдийн засгийг эргэлтэд оруулж, үнийн өсөлтийг бий болгох байтал тэр хөрөнгө ганцхан орон сууцны зээл рүү явчихаад байгаа юм. Энэ тохиолдолд эдийн засаг яаж өсөх вэ. Хүмүүсийн хөрөнгийг хааш нь чиглүүлэх вэ гэдэг урсгалыг зохицуулахын тулд ипотекийн зээлийг тодорхой хэмжээнд хязгаарлах хэрэгтэй л гэж боддог. Одоогоор төвлөрөл ихтэй нэлээд хэмжээгээр олгочихсон шүү дээ. Тиймээс нэмж олгох шаардлагагүй гэж бодож байна. Ерөнхийдөө тодорхой хугацаанд эдийн засгийн нөхцөл байдал харьцангуй сайжрах хүртэл нь хязгаарлах хэрэгтэй л гэж бодож байна. Өрхийн орлого нэмэгдсэн тохиолдолд үргэлжүүлэн олгож болно шүү дээ.



### Ж.Дэлгэрсайхан: Ипотекийн зээлийг огцом зогсоовол сайн нөлөө үзүүлэхгүй

*/Эдийн засагч/*

-Өнөөгийн нөхцөлд ипотекийн зээлийг үргэлжлүүлэх нь зөв. Нэгэнт эхэлсэн хөтөлбөрийг зогсоох гээд хэрэггүй. Гэхдээ энэ асуудлыг хэрхэн зөв шийдвэрлэх вэ гэдэг өөр асуудал. Хүүг нь нэмдэггүй юм аа гэхэд тухайн гэр бүл болон иргэний төлбөрийн чадварын шаардлагыг эдийн засгийн нөхцөлтэй тохируулах хэрэгтэй. Зээлийн нөхцөлийг нь эргэн харж, чангатгах ёстой гэж үзэж байна. Чанаргүй зээл олгохгүй тал дээр анхаарах нь хамгийн зөв бодлого юм. Гэхдээ тус хөтөлбөр зогссон ч ипотекийн зээлд хамрагдсан иргэдэд сөрөг нөлөө үзүүлэхгүй, хамаарахгүй гэдгийг онцолмоор байна. Харин цаашид үргэлжлүүлэх асуудал яригдана. Нэгэнт 70, 8 мянган хүн энэхүү хөтөлбөрт хамрагдсан учраас сууриар нь зогсоох үндэслэл гарахад төвөгтэй хүндрэл бий болно. Ипотекийн зээлээр дамжиж 3-4 их наяд төгрөг гарсан байгаа. Иймээс энэ хөтөлбөрт хамрагдчихсан хүмүүс тайван байж болно. Энэ асуудлыг буцаахад эдийн засгийн болон эрх зүйн боломж бага. Хамгийн гол нь төрийн бодлогыг дагаад баригдсан барилга байгууламж, барилгын салбарт хөрөнгө оруулсан, дууссан дуусаагүй шинэ барилгын борлуулалтад сөрөг нөлөө үзүүлнэ. Үүнтэй холбогдож зээлийн эргэн төлөлт багасна, барилгын салбарын ажиллагсдын төвшин, тэдгээрийн орлого буурах юм. Мөн эдийн засагт сөрөг нөлөө үзүүлнэ. Ипотекийн зээлд хамрагдах иргэдийн тоо эдийн засгийн хямралаас үүдэж хомсодсон байгаа. Тиймээс энэхүү зээлийн шалгуур болон орлогын баталгаатай байдлыг бий болгох хэрэгтэй. Хамгийн зөв шийдвэр бол ипотекийн зээлийг үргэлжлүүлж, төлбөрийн чадвар, шалгуурыг эдийн засгийн нөхцөлд нь тохируулж шинэчлэх л хэрэгтэй. Энэ хөтөлбөр анх хэрэгжиж эхлэхэд иргэдийн ойлголт муу байсан. Шинээр гэр бүл болж байгаа, шинээр орлоготой болж буй хүмүүсийн хүлээлт бий болсон. Барилгын салбарын хувьд ч гэсэн. Хэрвээ огцом зогсоовол аль аль талдаа сайн нөлөө үзүүлэхгүй.



### Б.Алтанцэцэг: Ипотекийн зээлийг үргэлжлүүлбэл эдийн засгийг аврах бодлогод нийцэхгүй

*/МУИС-ийн багш, эдийн засагч/*

-Ипотекийн зээлийг үргэлжлүүлбэл өнөөдөр эдийн засгийг аврах бодлогод яагаад ч нийцэхгүй. Зүй нь энэ бодлого маань хумигдах байх. Засгийн газар сонголт хийхэд улс төрийн хувьд ихээхэн хүнд шийдвэр байх болов уу.

## Сэтгүүлчийн дүгнэлт

## ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙГ ЗОГСООЧИХВОЛ ЯАСАН ЮМ

Н.ПУНЦАГБОЛД

Ойрын үед ипотекийн зээлийг зогсоох нь зөв үү, буруу юу гэдэг хэлэлцүүлэг маш их өрнөж байна. Олон ч эдийн засагч энэ тал дээр байр сууриа илэрхийлж, зөв, буруу л гэж байна. Өөр өөрийн үндэслэлийг ч гаргаж ирж байгаа. Мөн төр засгийнхан ч гэсэн гарц хайж байгаа юм билээ. Мэдээж өнгөрсөн хугацаанд хэрэгжсэн хамгийн зөв, ард түмний амьдралд маш хэрэгтэй хөтөлбөр байсан учраас эрх баригчид зогсоохгүй байх бүх аргыг л хэрэглэж таарна. Ж.Эрдэнэбат сайд ч гэсэн зөв гарцыг хайж байна гэсэн мэдээлэл эхнээсээ гарч л байна. Тэгвэл тэр зөв гарц чинь эдийн засаг сайжиртал ипотекийн зээлийг түр зогсоочихсон нь дээр юм биш үү. Шинээр ипотекийн зээл олгохгүй байя л гэсэн санаа. Ер нь ийм бодолтой эдийн засагчид цөөнгүй байгаа. Тэдний яриад байгаа зүйл, илэрхийлж буй байр суурь яг өнөөдрийн эдийн засгийн нөхцөл байдлын үед бол зөв юм биш үү. Мэдээж манайх шиг иргэд нь орлого багатай, бараг л шалан дээр уначихсан. Эсрэгээрээ өртөг нь тэнгэрт тулчихсан. Сарын цалингаа илүүчлээд, 20, 30 жил хураагаад ч байр авч чадахгүй ч байж магадгүй нөхцөлд ипотекийн зээл бол хамгийн зөв хөтөлбөр. Иргэд байр сууцтай болж, ая тухтай амьдрах нөхцөл нь бүрдэнэ. Цаашлаад барилгын компаниуд нь орон сууцаа борлуулах нэг сувагтай байна. Тэр хэрээрээ барилгачид ажилтайгаа байх нь ойлгомжтой. Дээрээс нь утаагаа шийдэх том алхам. Энэ мэтээр сайн талыг нь тоочоод байвал их. Хэрвээ зогсоочихвол барилгын компаниуд хэцүүдэнэ. Иргэд байр авах боломжгүй болно. Барилгачид ажилгүй болж, “хог дээр үсэрнэ” гээд сөрөг тал байгааг ч эдийн засагчид ярьж байна. Мэдээж сөрөг тал байлгүй л яах вэ. Гэхдээ л аливаа зүйл зогсох ёстой газраа зогсч байх нь зөв юм биш үү. Өнөөдөр Монголын эдийн засаг туйлдаа хүрчихлээ. Өнгөрсөн хугацаанд АН-ынхан ипотекийн найман хувийн зээлийг зогсоохгүйн тулд гурван их наяд төгрөг шидсэн. Гэхдээ мөнгө хэвлэж тараасан нь балаг ихтэй байлаа гэж одоогийн эрх баригчид яриад байна. Дээрээс нь одоогийн эрх баригчид хоёр их наяд төгрөгийн эх үүсвэрийг мөнгө хэвлэхгүйгээр, зөв замаар бий болгож, ипотекийн зээлийг үргэлжлүүлэх арга хайж байна гэнэ ээ.

Төсөв нь хоёр их наядаар тасраад, орлого нь хүрэхгүй балраад, хэмнэлтийн горимд шилжихээр улайрч байхад тэр бүтэх үү. Түүний оронд зүгээр л хэсэг зогсоочих хэрэгтэй. Тэглээ гээд одоо зээл авчихсан байгаа хүмүүст ямар ч нөлөө байхгүй. Харин шинээр зээл авах гэж байгаа хүмүүст хэсэг зуур бэрхшээл тулгарах байх. Гэхдээ ипотекийн зээлийг олгохгүй байлаа гээд бүх зүйл дуусчихна гэж байхгүй биз дээ. Өнөөдөр орон сууцны үнэ хөөсрөөд, ам.метр нь 2, 3, цаашлаад 4, 5 сая төгрөгт хүрчихээд байгаа нь нэг талаараа ипотекийн зээлтэй холбоотой. Засгийн газраас яаж ийгээд мөнгө гаргаад, ипотекийн зээл олгоод байхаар барилгын компаниуд орон сууцныхаа үнийг бууруулах гэж яарахгүй байна шүү дээ. Ямар ч байсан ипотекийн зээлээр цөөн ч болов иргэн байр аваад байгаа болохоор. Өнөөдөр барилгын салбар хямарлаа, орон сууц зарагдахгүй байна л гээд байдаг. Гэтэл яг ачир дээрээ шинэ байрны үнэ буурсан уу. Үгүй, үнэтэй хэвээрээ л байна. Хэрвээ ипотекийн зээлийг хэсэг хугацаанд зогсоочихвол барилгын салбарынхан үнээ буулгах боломжтой. Өнөөдөр нэгдүгээр хороололд барилга барьж байгаа нэг компани захиалгаа гурван янзаар авч байна. Мөнгөө 100 хувь бэлэн төлбөл 1.2 сая, тодорхой графикийн дагуу богино хугацаанд 30, 20 хувиар нь хуваагаад өгвөл 1.4, банкны зээлд хамрагдвал 1.6 сая төгрөгөөр зарна гэж байгаа юм, ам.метрээ. Уг нь тэр компани байраа 1.2 саяар зарахад ч ашигтай ажиллах нь тодорхой байгаа биз. Гэтэл банкны зээл хамрагдаад, төлбөрийн мөнгө орж ирэх хугацаа жаахан нь нэмэгдчихээр 1.6 сая, түүнээс ч өндөр болчихдог нь ариун явдал уу. Зүгээр л хөөсрөл шүү дээ. Шууд бэлэн мөнгөө өгөөд авч чадахгүй дундажаас доогуур орлоготой иргэдийг шулж байгаа шулаа. Үүнийг зогсоох цаг болсон. Тиймээс л ипотекийн зээлийг хэсэг зуур зогсоож, энэ “хөөс”-ийг хагалмаар байна. Дээрээс нь ипотекийн зээл зогслоо гээд барилгын компаниуд тэр чигээрээ сүйрчихнэ гэж бодохгүй байна. Өнөөдөр зарим компаниуд шууд хүүгүй зээл өгч байгаа. Хажуудаа ББСБ байгуулаад, найман хувийн хүүтэй зээл өгч байгаа барилгын компани ч байна. Иргэнтэй янз бүрийн байдлаар тохиролцож, байраа борлуулаад эхэллээ. Энэ чинь орон сууцны эрэлт багасаад, хүн авахгүй болохоор хэт өндөр шаардлага, үнээ буулгаж эхэлж, өөрсдөө зах зээлд өрсөлдөх арга замаа хайж байна гэсэн үг. Ипотекийн зээлийг зогсоочихвол бүгд л өөр өөрийн арга замыг хайна. Хамгийн гол нь хэтэрхий хадчихаад байгаа үнэ буурах боломж байгаа гэдгийг эдийн засагчид хэлж байна. Тиймээс жаахан зоримог шийдвэр гаргамаар л байгаа юм.

# ДЭЛХИЙ

## ОХУ, Японы төрийн тэргүүнүүд Владивостокт уулзана

Энэ долоо хоногт ОХУ-ын Владивосток хотод эхлэх Дорны эдийн засгийн хоёрдугаар чуулга уулзалтын үеэр Ерөнхий сайд Шинзо Абэ Оросын Ерөнхийлөгч В.Путинтай уулзах ажээ. Японы Сайд нарын танхимын Ерөнхий нарийн бичгийн дарга Ёшихидэ Суга энэ талаар "Владивостокт болох Дээд хэмжээний уулзалтын үеэр Япон-Оросын харилцаатай холбоотой олон асуудал, тэдгээрийн дотор В.Путины Японд хийх айлчлалын талаар хэлэлцэнэ" гэж мэдэгдлээ. Мөн "Энхийн гэрээ байгуулах асуудлаар Москватай яриа хэлэлцээ хийхэд Японы тал бэлэн байгаа"-г онцлон тэмдэглэсэн байна. Энэ уулзалтыг Оросын төрийн тэргүүний Хэвлэлийн нарийн бичгийн дарга Дмитрий Песков ч мөн баталжээ.

## Лос-Анжелесын нисэх онгоцны буудалд буун дуу гарлаа

АНУ-ын Калифорни мужийн Лос-Анжелес хотын олон улсын нисэх онгоцны буудалд ням гарагийн орой буун дуу гарчээ. Улмаар ийм мэдээлэл гарсантай холбогдуулан нисэх буудлын зарим хэсгийн үйл ажиллагаа зогсоосон байна. Нисэх онгоцны буудлын албан ёсны твиттер хуудаст ч мөн энэ талаар нийтлэгдсэн байх бөгөөд одоогоор төв хэсгийн терминалын гарах болон орох хэсгийг түр хугацаагаар хаасан байна. Буун дуу гарах үед хүмүүс бүгд нисэх онгоцны буудлыг орхин гарсны зэрэгцээ явган хүний зам дээр ачаа бараагаа орхиж явсан тохиолдол ч нэлээд гарчээ. Одоогоор хүн гэмтэж бэртсэн гэсэн мэдээлэл байхгүй байгаа юм. Өмнө нь ийм тохиолдол Нью Йорк хотын Жон Кеннидигийн олон улсын нисэх онгоцны буудалд гарч байлаа. Тус нисэх онгоцны буудалд энэ сарын 14-ний өдөр гурван ч удаа буун дуу гарсан юм.

ТЭД БИДНИЙ ТУХАЙ

# Financial Times: ОУВС-ААС ТУСЛАМЖ ГУЙХ НЬ ЦАГ ХУГАЦААНЫ Л АСУУДАЛ

August 25, 2016 9:37 am

Mongolia tightens belt as debt payments loom

Lucy Hornby in Ulan Bator

Share Author alerts Print Clip Comments



Mongolia's new government has revealed a budget deficit equivalent to nearly one-fifth of economic output, underlining the dire financial conditions that have sent the currency tumbling.

Even after stringent cost-cutting measures outlined by the Mongolian People's party,

Б.ДАВАА

*Их Британийн "Финансиал таймс" сонины сэтгүүлч Люси Хорнбайны бичсэн Монголын эдийн засгийн нөхцөл байдлын талаархи нийтлэлийг энэ удаагийн дугаартаа онцолж байна.*

...Монголын шинэ Засгийн газар санхүүгийн алдагдал Дотоодын нийт бүтээгдэхүүний бараг 20 хувьд хүрснийг зарласан билээ. Валютын ханш нь ч тасралтгүй унасны улмаас санхүүгийн хямралд хүрээд байна. Парламентын бүх нийтийн сонгуульд үнэмлэхүй ялалт байгуулсан Монгол Ардын нам санхүүгийн эл хямралыг гэтлэхийн тулд төсвийн зардлаа танах төлөвлөгөөг гаргасан. Гэсэн ч Монголын санхүүгийн зах зээл дэх орлого нь таван их наяд 340 тэрбум, харин зарлага нь есөн их наяд 700 тэрбум төгрөг байгаа юм. Ингэхээр төсвийн алдагдал нь хуульд заасан ДНБ-ий дөрвөн хувийг аль хэдийнэ давж, 18 хувь болсон үзүүлэлттэй байна. Гурван сая хүн амтай, ДНБ-ий хэмжээ 12 тэрбум ам.доллар Монгол Улс уул уурхай томоохон орон зайг эзлэх бөгөөд гол экспортлогч орон нь Хятад. Уул уурхайн орлого нь нэмэгдэж, Олон улсын валютын сангаас зээл авах урьдчилгаанд хүрч байгаа ч, сүүлийн үед зэс, нүүрсний үнэ унасны улмаас Монголын эдийн засаг том цохилт амсаад байгаа юм. Ирэх жилийн гуравдугаар сард Засгийн газрын үнэт цаасны байгууллагууд Монголын Хөгжлийн банкнаас гаргасан бондын 580 сая ам.долларыг буцаан төлнө. Мөн өнгөрсөн хоёр жилд Хятадын төв банкнаас своп хэлцлийн хүрээнд зээлсэн 1.7-1.8 тэрбум ам.доллароо төлөх ёстой.

Тэгвэл танах зарчим баримталж буй МАН төсвийн тодотголд төрийн албаны орон тоог бууруулах, татвар нэмэх, тэтгэвэрт гарах насыг нэмэгдүүлэх гэх мэт заалтыг тусгасан байна. Түүнчлэн, уул уурхайн оргил үед төсөвт суулгасан оюутны тэтгэлгээс гадна нийгэмд томоохон байр суурь эзлэх хүүхдийн мөнгө зэрэг халамжуудаа ч хасах тухай дурьджээ. Азийн хөгжлийн банкны эдийн засагч Ёоланда Фернандес "Санхүүгийн хүнд дарамттай тулгарна гэдгийг тооцоолж байсан ч, ийм хэмжээнд оччихсон байна гэж төсөөлж ч байсангүй" гэж хэлсэн байдаг. Түүний үзэж буйгаар Монголын Засгийн газар цаашдаа хүндхэн хоёр жилтэй нүүр тулах гэнэ. МАН-ын хувьд одоогоор Олон улсын байгууллагаас албан ёсоор тусламж хүсээгүй байгаа. Гэхдээ ажиглагчдын үзэж буйгаар төсвийн тодотгол батлагдаж, энэ оны Засгийн газрын төлөвлөгөөг батална чихвал Олон улсын Валютын сангаас тусламж авах нь цаг хугацааны л асуудал болж хувирах аж. Энэ сард Олон улсын валютын сангийн төлөөлөгчид Монголд зочилсон. Монгол 2009 онд зээлсэн 232 сая ам.доллароо эргүүлэн төлсөн нь экспортын бүтээгдэхүүний үнэ өссөнтэй холбоотой байжээ.

Нийслэл Улаанбаатар хотын зах хэсэг дэх гэр хороололд цайны газар ажиллуулдаг Эрдэнэбаярын хэлж буйгаар Засгийн газрын олон нийтэд зарласан санхүүгийн хямрал жирийн иргэдийн хувьд гайхаад байх зүйл биш гэнэ. Түүний цайны газрын орлого, үйлчлүүлэгчдийн амьдралыг харахад л хар аяндаа улсын нөхцөл байдал ойлгогдох аж.

Цайны газраар үйлчлүүлэх үйлчлүүлэгчид ч хүүхдийн мөнгөны асуудал, банкны зээлийн хүүний талаар ам уралдан ярьцгаах юм билээ. Төв банкнаас валютын ханшийн уналтыг тогтоон барихын тулд бодлогын хүүгээ 15 хувь болгосон нь тэдний ярианы сэдэв болж буй нь энэ. Тэдний дунд суух арав гаруй насны таван хүүхэдтэй Нэргүй гэх өрх толгойлсон эмэгтэй худалдааны төвд цэвэрлэгч хийдэг бөгөөд ажлынхаа цагийг уртасгаж, хүүхдүүдээрээ ч гэсэн ажил хийлгэхээр төлөвлөж байгаа гэнэ. "Хүүхдийн мөнгө бидэнд их нэмэр болж байсан. Зөвхөн хүүхдийнхээ тэтгэмжээр амьдарч байгаа гэр бүлүүд ч олон байгаа" гэж тэр эмэгтэй бидэнд ярьсан юм. Эцэст нь тэмдэглэхэд, Монголын нэг өрхийн дундаж орлого өмнөх жилийнхтэй харьцуулахад 10 орчим хувиар багасч, ажилгүйдэл ч нэмэгдсээр байна.

# ДАРААХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ГЭРЧИЛГЭЭГ ХҮЧИНГҮЙД ТООЦОВ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Т.Очирдарь | 1805НАА | Ахмед | ЗИЛ-130 | 0214755 | 2016-04-25 |
| Д.Алтанзул | 4017дор | Н.Батхишиг | Hyundai Libero | 0402897 | 2016-04-25 |
| Д.Алтанзул | 3991дор | Б.Чойбилсүрэн | Mazda titan | 0314995 | 2016-04-25 |
| Д.Алтанзул | 4503дор | Т.Чулуунсүх | Hyundai sonata | 0545557 | 2016-04-25 |
| Д.Алтанзул | 5427доа | Б.Амарсанаа | Kia bongo | 0198646 | 2016-04-25 |
| Д.Алтанзул | 4238дор | Ч.Майдар | Hyundai sonata | 0253724 | 2016-04-25 |
| Д.Алтанзул | 2126дор | Г.Цолмондорж | Mazda | 0802012 | 2016-04-25 |
| Д.Алтанзул | 3906дор | А.Баяндалай | Nissan sunny | 0019774 | 2016-04-25 |
| Д.Алтанзул | 5557доа | ЭнхАмгалан | Nissan Terrano | 0106497 | 2016-04-25 |
| Д.Алтанзул | 5497доа | ДМНИБХХОЛБОО | Hyundai Porter | 0205150 | 2016-04-25 |
| Д.Алтанзул | 2435доа | Т.Галбадрах | Hyundai Porter | 0145400 | 2016-04-25 |
| Д.Алтанзул | 0099доа | Энхтөр | Toyota Harrier | 0539964 | 2016-04-25 |
| Д.Алтанзул | 2606дор | Баттүвшин | Toyota carina | 0055504 | 2016-04-25 |
| Д.Алтанзул | 9596доа | Занданбал | starex | 0036477 | 2016-04-25 |
| Д.Алтанзул | 0395доа | Энхмөрөн | Nissan terracan | 0186266 | 2016-04-25 |
| Д.Алтанзул | 6000доа | С.Галт | Уаз 2206 | 0944705 | 2016-04-25 |
| Д.Алтанзул | 1649дор | Алтанцолбо | Kia hino | 0241487 | 2016-04-25 |
| Д.Алтанзул | 3598дор | Ганзориг | Hyundai Porter | 0425570 | 2016-04-25 |
| Д.Алтанзул | 8048доа | Баатарсүрэн | Mazda | 0386220 | 2016-04-25 |
| Д.Алтанзул | 3359ДОР | Мөнхбаатар | Istana | 1035235 | 2016-04-25 |
| Д.Алтанзул | 3562доа | М.Энэбиш | Toyota Cresta | 0539989 | 2016-04-25 |
| Д.Алтанзул | 5937дор | О.Сугар | Nissan Pulsar | 1093233 | 2016-04-25 |
| Д.Алтанзул | 4842доа | Дамдинсүрэн | Hyundai Excel | 0251201 | 2016-04-25 |
| Д.Алтанзул | 1134дор | Чулуунсүх | Mitsubishi L 200 | 1578214 | 2016-04-25 |
| Д.Алтанзул | 3823доа | Батзориг | Уаз31514 | 0076063 | 2016-04-25 |
| Д.Алтанзул | 3962дор | МөнхОд | Toyota Avensis | 0725997 | 2016-04-25 |
| Д.Алтанзул | 3532дор | Батзориг | Toyota allex | 0918651 | 2016-04-25 |
| Д.Алтанзул | 1841дор | Баатарчулуун | Toyota Prius | 0785677 | 2016-04-25 |
| Д.Алтанзул | 0800дор | Хэрлэн Сумын ЗДТГ | Lexus 470 | 0423287 | 2016-04-25 |
| Д.Алтанзул | 5911ДОР | Капитал банк | Honda Fit | 0725934 | 2016-04-25 |
| Д.Энхдэлгэр | 9855унд | б.ганболд | h.accent | 0927269 | 2016-04-26 |
| А.Гарьдмагнай | 6576сэа | Хаянхярваа | K.Frontier | 0164942 | 2016-04-26 |
| А.Сарантуяа | 4981убб | сүхбаатар | королла | 995247 | 2016-04-26 |
| А.Сарантуяа | 4403унд | хаан банк | приус | 1057751 | 2016-04-26 |
| Н.Гэрэлмаа | 41-64 убв | Н.Ганбат | H.Mighty | 0296708 | 2016-04-26 |
| Н.Шүрэнотгон | 2125унү | б.нарантуяа | t.pruis | 1593289 | 2016-04-26 |
| А.Сарантуяа | 4498уба | хаан банк | приус | 930921 | 2016-04-26 |
| Д.Энхдэлгэр | 6858убх | ч.энх-амгалан | nissan blueberd | 042644 | 2016-04-26 |
| Т.Очирдарь | 0390УБМ | Бат-эрдэнэ | Mitsubishi pajero | 0173760 | 2016-04-26 |
| Э.Цолмон | 5680унэ | есөн шижир ххк | т:приус | тя1184587 | 2016-04-27 |
| Э.Цолмон | 8360унз | Б.Анхбаяр | faw ca3252 | тя1189652 | 2016-04-27 |
| Э.Цолмон | 5789уби | О.Мандал | Т.Приус | Тя1126299 | 2016-04-27 |
| Э.Цолмон | 3909уно | Р.Дүүрэнжаргал | Н.Патрол | Тя0664937 | 2016-04-27 |
| Э.Цолмон | 0711уно | Ц.Нарантунгалаг | LX 570 | тя0356188 | 2016-04-27 |
| Э.Цолмон | 4353унл | М.нарангэрэл | Т.Приус | тя0858211 | 2016-04-27 |
| Э.Цолмон | 8216унв | А.Пүрэвдорж | isuzu elf | тя0507572 | 2016-04-27 |
| Э.Цолмон | 4421уня | А.Пүрэвдорж | N.Vanete | тя0797198 | 2016-04-27 |
| Э.Цолмон | 7125унз | Тайкун ххк | Т.Приус | тя1201403 | 2016-04-27 |
| Э.Цолмон | 9253унч | Г.пүрэвдаян | T.Highlander | Тя0325839 | 2016-04-27 |
| Э.Цолмон | 7413убл | С.Дуламханд | T.Mark 2 | Тя01100297 | 2016-04-27 |
| Э.Цолмон | 7413унк | Ч.Уранчимэг | Т.Приус | тя0641889 | 2016-04-27 |
| Э.Цолмон | 8192өмө | Д.Лхагвасүрэн | N.Datsun | АЯ0119236 | 2016-04-27 |
| Э.Цолмон | 5855убх | Р.Төмөрбаатар | M.pajero | тя0962957 | 2016-04-27 |
| Э.Цолмон | 5855убх | Р.Төмөрбаатар | M.pajero | тя0962957 | 2016-04-27 |
| Э.Цолмон | 3199зан | Р.Төмөрбаатар | K.Pnino | тя0962957 | 2016-04-27 |
| Э.Цолмон | 5667зан | Б.Мягмарсүрэн | T.Allion | Тя0656138 | 2016-04-27 |
| А.Сарантуяа | 2686унг | мандухай | приус | 503878 | 2016-04-27 |
| Д.Энхдэлгэр | 4311УБП | М.Баярмөнх | v.touareg | 0897904 | 2016-04-27 |
| Т.Очирдарь | 6862УНЦ | нэт капитал ббсб | Hyundai verna | 0609841 | 2016-04-27 |
| А.Сарантуяа | 5923ач | монпорт ххк | HJT | 161213 | 2016-04-27 |
| А.Сарантуяа | 9038ач | итайкар ххк | HJT | 1189505 | 2016-04-27 |
| Б.Цэцэгмаа | 2389убе | төрийн банк | приус | 823490 | 2016-04-27 |
| Н.Гэрэлмаа | 21-64 унп | Ж.Энхбор | H.Porter | 1002385 | 2016-04-27 |
| Д.Энхдэлгэр | 5782уб | ийстдаймонд дриллинг ххк | cat | 0786393 | 2016-04-27 |
| Д.Энхдэлгэр | 1082убн | ийстдаймонд дриллинг ххк | ural | 0403600 | 2016-04-27 |
| Ч.Оюунтуяа | 6892убч | Уртнасан | toyota prius | тя1168466 | 2016-04-27 |
| Т.Уртнасан | 1523ун | хаслизинг ххк | экскаватор | 471468 | 2016-04-27 |
| Т.Очирдарь | 0181УНП | Чанцалмаа | Toyota corolla | 0587757 | 2016-04-27 |
| А.Сарантуяа | брз1221 | мөнх-орчлон | мираже | 962138 | 2016-04-27 |
| А.Сарантуяа | 6989ун | эбердигммонгол ххк | doosan | 423835 | 2016-04-27 |
| А.Сарантуяа | 3344ун | эбердигммонгол ххк | doosan | 550551 | 2016-04-27 |
| А.Сарантуяа | 3060ун | эбердигммонгол ххк | doosan | 392151 | 2016-04-27 |
| А.Гарьдмагнай | 6081дах | Цэрэннадмид | T.Vitz | 0303089 | 2016-04-27 |
| Н.Гэрэлмаа | 79-45 убү | Ц.Мягмартогтох | N.Navara | 0877513 | 2016-04-27 |
| Т.Очирдарь | 5891УНЛ | АЛТАЙН ХҮДЭР ХХК | North benz | 0166102 | 2016-04-27 |
| Т.Очирдарь | 5380БЧ | АЛТАЙН ХҮДЭР ХХК | Чиргүүл | 0872990 | 2016-04-27 |
| Т.Очирдарь | 4090УНЧ | Мягмардулам | Hyundai accent | 0339838 | 2016-04-27 |
| Ч.Оюунтуяа | 4462убн | Ганзориг | hyundai accent | тя0975362 | 2016-04-27 |
| Т.Очирдарь | 6393УБП | хаан банк | Toyota prius | 0999137 | 2016-04-27 |
| Б.Ганболд | 1875бнх | Баярсайхан | портер | ая0742007 | 2016-04-27 |
| Б.Ганболд | 1875бнх | Баярсайхан | портер | ая0742007 | 2016-04-27 |
| Т.Очирдарь | 7915УБЕ | хаан банк | Toyota prius | 0857758 | 2016-04-27 |
| Б.Мөнхгэрэл | 0262дго | Б.БААТАРЖАВ | ADMIRAL ZXAUTO | 0886280 | 2016-04-27 |
| Б.Мөнхгэрэл | 9362ДГО | Х.ЭРДЭНЭБААТАР | HYUNDAI GRACE | 1081447 | 2016-04-27 |
| Т.Очирдарь | 4504БЧ | Худалдаа хөгжлийн банк | Чиргүүл | 0105925 | 2016-04-28 |
| Ч.Оюунтуяа | 4577унв | Эрдэнэ-Очир | toyota prius | тя01140838 | 2016-04-28 |
| А.Сарантуяа | 7973өма | итайкар ххк | нортбенз | 666137 | 2016-04-28 |
| А.Сарантуяа | 7973өма | итайкар ххк | нортбенз | 666137 | 2016-04-28 |
| А.Сарантуяа | 6041ач | итайкар ххк | HJT | 145116 | 2016-04-28 |
| Н.Гэрэлмаа | 29-79 убг | Ж.Баасансүрэн | H.Sonata-5 | 0781542 | 2016-04-28 |
| Т.Очирдарь | 3882УБЯ | Чөдөр-эрдэнэ | LEXUS LX570 | 1189863 | 2016-04-28 |
| Ч.Оюунтуяа | 7693унү | Мөнхболд | chevrolet cruze | тя0696789 | 2016-04-28 |
| Т.Уртнасан | 4736УНК | АМЭ ТРЕЙД ХХК | ЗУУРМАГ ТУСГАЙ | 641206 | 2016-04-28 |
| Б.Цэцэгмаа | 8997унү | их эвсэг жаргал ххк | chevrolet cruze | 1159794 | 2016-04-28 |
| Ч.Оюунтуяа | 7668убп | Лхагвадагва | Hyundai verne | ая0077258 | 2016-04-28 |
| Н.Шүрэнотгон | 5294убт | д.ууганбаяр | t. mark 2 | 1013667 | 2016-04-28 |
| Б.Цогтгэрэл | 3088уну | чулуунтулга | crown | 0954745 | 2016-04-28 |
| Н.Гэрэлмаа | 79-46 унн | Б.Энхтөр | Isuzu | 0058718 | 2016-04-28 |
| Н.Гэрэлмаа | 23-43 гч | Б.гансэлэм | чиргүүл | 0286262 | 2016-04-28 |
| Б.Уянга | 1298 ОЧ | Лхагва Баярмагнай | ГКБ 817 | 1801041 | 2016-04-28 |
| Б.Уянга | 5006 ТӨВ | Жамсран Нармандах | Teangue EQ1041 | 0272191 | 2016-04-28 |
| Б.Уянга | 8457 ТӨА | Цэвээнжав Барсболд | Hyundai Porter | 0037532 | 2016-04-28 |
| Б.Уянга | 8457 ТӨА | Цэвээнжав Барсболд | Hyundai Porter | 0037532 | 2016-04-28 |
| Б.Уянга | 1093 ТӨВ | Доржпалам Батбуян | Kia Bongo | 0146490 | 2016-04-28 |
| Б.Уянга | 8689 ТӨВ | Жавзан Чулуунбат | Toyota Hilux | 0919078 | 2016-04-28 |
| Б.Уянга | 8745 ТӨВ | Сүрэнхорлоо Бадамсүрэн | Toyota Sprinter | 0919986 | 2016-04-28 |
| Б.Уянга | 7987 ТӨА | Ганбат Базаррагчаа | Hyundai Porter | 0006193 | 2016-04-28 |
| Б.Уянга | 4198 ТӨВ | Ганбат Бакарбат | Steyr ZZ1190 | 0324698 | 2016-04-28 |
| Б.Уянга | 3526 ТӨВ | Цэндсүх Шатар | Hyundai Porter | 0677631 | 2016-04-28 |
| Б.Уянга | 1520 ТӨА | Чойжамц Цэдэнбал | Toyota Voltz | 0749752 | 2016-04-28 |
| А.Сарантуяа | 6569убс | цогбаяр | приус | 1122321 | 2016-04-28 |
| Б.Уянга | 5026 ТӨВ | Нармандах Машбат | Hyundai Porter | 0387901 | 2016-04-28 |
| Н.Гэрэлмаа | 3902 убк | Л.Даваа | N.Sunny | 0586180 | 2016-04-28 |
| Б.Цогтгэрэл | 1634гаү | гантулга | terano | 0365827 | 2016-04-28 |
| А.Сарантуяа | 0394убн | бичил глобус ббсб | пулсар | 214394 | 2016-04-28 |
| Б.Ганболд | 3916бна | Доржсүх | Уаз 3962 | ая0295086 | 2016-04-28 |
| Б.Мөнхгэрэл | 3069ГЧ | Г.АМАРЦОГТ | LHX | 0391190 | 2016-04-28 |
| Ч.Оюунтуяа | 8622унз | Таван толгой транс ххк | Northbenz nd4250 | ат0143973 | 2016-04-29 |
| Н.Гэрэлмаа | 36-13 уну | замын битум ххк | Beiben | 0245023 | 2016-04-29 |
| Н.Гэрэлмаа | 69-94 убу | Т.Бямбаа | S.Musso | 0363527 | 2016-04-29 |
| Т.Очирдарь | 6966УНП | Гантулга | Toyota chaser | 1146560 | 2016-04-29 |
| Т.Очирдарь | 4400УБЦ | Батболд | Mercedes benz | 0231797 | 2016-04-29 |
| А.Сарантуяа | 4999унт | сор секьюрити ххк | хаймер н2 | 295840 | 2016-04-29 |
| А.Сарантуяа | 6939унэ | цэрэнханд | королла | 936685 | 2016-04-29 |
| Н.Шүрэнотгон | 7833унл | монос дэлгэрэх ххк | hyundai accent verna | 634228 | 2016-04-29 |
| И.Ловонгончиг | 8900 оро | Ж.Самбадагва | Hyundai Avante | ая0348373 | 2016-04-29 |
| И.Ловонгончиг | 9630хөа | О.Баярмаа | Isuzu Wagon | ая0334284 | 2016-04-29 |
| И.Ловонгончиг | 8598ун | Ж.Мөнхбат | Solar 290 | ая0571882 | 2016-04-29 |
| И.Ловонгончиг | 1461оро | Ц.Энхтайван | Hyundai Grace | ая0149234 | 2016-04-29 |
| И.Ловонгончиг | 8313оро | Д.Эрдэнэмөнх | Nissan X-trail | ая0330545 | 2016-04-29 |
| И.Ловонгончиг | 0573орз | Х.Буяндалай | Yingang | ая0000140 | 2016-04-29 |
| И.Ловонгончиг | 0623орз | Ц.Батжаргал | Dayun | ая0000186 | 2016-04-29 |
| И.Ловонгончиг | 0357орз | С.Батмөнх | Yingang | ая0000004 | 2016-04-29 |
| И.Ловонгончиг | 0777орз | 7349унз | Kia Fronter | Ая0037986 | 2016-04-29 |
| И.Ловонгончиг | 5971оро | Э.Оргил | Isuzu Bighorn | ая0212603 | 2016-04-29 |
| И.Ловонгончиг | 5566оро | С.Гантогоо | Toyota Land Criuser | Ая0713168 | 2016-04-29 |
| И.Ловонгончиг | 1106оро | С.Гантулга | Hyundai Sonota 6 | Ая0446167 | 2016-04-29 |
| И.Ловонгончиг | 8744оро | Ц.Алтанхуяг | Toyota Corolla | ая0839043 | 2016-04-29 |
| И.Ловонгончиг | 0579орз | Х.Моломдалай | Mustang | ая0000142 | 2016-04-29 |
| И.Ловонгончиг | 3895ора | Д.Машбат | Isuzu Wizard | ая0187261 | 2016-04-29 |
| И.Ловонгончиг | 1024орх | Д.Золжаргал | Mazda Titan | ая0244074 | 2016-04-29 |
| И.Ловонгончиг | 2304орх | О.Эрдэнэболд | Toyota Prius | ая1155566 | 2016-04-29 |
| И.Ловонгончиг | 7106оро | С.Дарханбаатар | Hyundai Sonota 5 | ая1184331 | 2016-04-29 |
| И.Ловонгончиг | 2543оро | М.Шаравдорж | Hyundai Porter | ая0146455 | 2016-04-29 |
| Н.Шүрэнотгон | 3134убз | т.ганболд | land criuser prado | 338601 | 2016-05-01 |
| Н.Шүрэнотгон | 5851убп | д.батжаргал | t.pruis | 1196055 | 2016-05-02 |
| Б.Цэцэгмаа | 8913убр | нэт капитал | приус | 1017924 | 2016-05-02 |
| Т.Очирдарь | 1165НАА | Даваахүү | Hyundai accent | 0948417 | 2016-05-02 |
| Б.Цэцэгмаа | 9473УНТ | ЭНХЦЭЦҮҮН | ИМПРЕЗА | 1159417 | 2016-05-02 |
| Ч.Оюунтуяа | 4546унг | Баатар | T.mark 2 | тя0809267 | 2016-05-02 |
| Ч.Оюунтуяа | 7653убп | Транс капитал ббсб | toyota prius | тя1102670 | 2016-05-02 |
| Т.Очирдарь | 7176ХОҮ | Ихзориг | ПАЗ | 1003655 | 2016-05-02 |
| Б.Цогтгэрэл | 8678убр | нэт капитал | land cruiser | 0625247 | 2016-05-02 |
| А.Сарантуяа | 8087унм | шармөнх | рав-4 | 1147992 | 2016-05-02 |
| Н.Шүрэнотгон | 9105убо | мон илч ххк | hino ranger | 634636 | 2016-05-03 |
| А.Сарантуяа | 2551унц | адъяа | inspire | 191149 | 2016-05-03 |
| Т.Уртнасан | 8938унө | тэсээ | kluger | 638484 | 2016-05-03 |
| Ч.Оюунтуяа | 4121убр | Мөнх-очир | hyundai porter | тя1041741 | 2016-05-03 |
| Н.Шүрэнотгон | 6244унэ | г.тэмүүжин | corolla runx | 10822125 | 2016-05-03 |
| Н.Гэрэлмаа | 29-93 унс | Б.Батцэрэн | t.harrier | 0975988 | 2016-05-03 |
| Н.Гэрэлмаа | 25-79 убц | Б.эрдэнэтөгс | M.Chariot | 0107568 | 2016-05-03 |
| Б.Цэцэгмаа | 9278унв | эл икс то ххк | грейс | 621646 | 2016-05-03 |
| Б.Цэцэгмаа | 9278унв | эл икс то ххк | грейс | 621646 | 2016-05-03 |
| Ня.Мөнхзул | 0202 | ZDFDF | FGDFG | GFDGDFG | 2016-05-03 |
| Н.Шүрэнотгон | 5383унб | цэвээн тунгалаг | mitsubishi fuso | 448372 | 2016-05-03 |
| А.Сарантуяа | 9850унп | хан агьт ххк | приус | 1131922 | 2016-05-03 |
| Т.Очирдарь | 3388УБК | Баянмөнх | Toyota mark 2 | 0351859 | 2016-05-03 |
| Ч.Оюунтуяа | 4843унм | Хас банк | toyota raum | ат0158855 | 2016-05-03 |
| Б.Цэцэгмаа | 3334унл | бямбадамжин | кроун | 1195156 | 2016-05-04 |
| Т.Уртнасан | 4880уну | их булгийн тохой ххк | isuzu elf | 36888 | 2016-05-04 |
| А.Сарантуяа | 3994убк | нарантуяа | либерти | 385476 | 2016-05-04 |
| А.Сарантуяа | 7125уннг | бичил глобус ббсб | сонота-5 | 254594 | 2016-05-04 |
| П.Тунгалаг | 0050УНЧ | ЦЭНД-АЮУШ | ХАЙМЕР | 0251881 | 2016-05-04 |
| Д.Энхдэлгэр | 4022унз | ч.бэх-очир | hongyan | 1169753 | 2016-05-04 |
| Н.Гэрэлмаа | 92-67 унү | Г.Цоггэрэл | T.Passo | 0616863 | 2016-05-04 |
| А.Сарантуяа | 2597уну | бямбадорж | приус | 1144169 | 2016-05-04 |
| А.Гарьдмагнай | 7671дах | Энхтүвшин | T.Prius 11 | 0225439 | 2016-05-04 |
| А.Гарьдмагнай | 8578дар | Эрдэнэбаатар | H.Grace | 0074916 | 2016-05-04 |
| Ч.Оюунтуяа | 5646убх | Гантуяа | toyota prius | тя01148836 | 2016-05-04 |

# ШУУРХАЙ МЭДЭЭ

## Шүүгчдийн цалин нэмэгдэх нь авлига авах эрсдэлийг багасгана гэв

Ц.СОЛОНГО

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс сар бүр зохион байгуулдаг ээлжит хурал өчигдөр боллоо. Энэ удаагийн хуралдааныг “Шүүхийн төсөв, шүүгчийн цалин” сэдвийн хүрээнд Монголын Хуульчдын холбооны Шүүгчдийн хорооны тэргүүн Ц.Оч, МУИС-ийн ХЗС-ийн дэд профессор, доктор О.Мөнхсайхан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Т.Мэндсайхан нар танилцуулав. Хурлын үеэр Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Т.Мэндсайхан “2016 оны төсвөөр шүүхийн төсөв улсын нийт төсвийн зарлагын дүнгийн 0.66 хувьтай тэнцэж байна. Төсвийн тодотголоор дүнгийн хувь буураад 0.46 болж байна. Энэ байдлаас харахад шүүх, эрх мэдлийн байгууллагад хандаж байгаа төрийн бодлого ялгаварлан гадуурхсан, шүүхийн ажлын бүтээмжийг дордуулсан байдлаар хандаж байна. Олон улсын жишигт ОХУ нийт төсвийнхөө 2.1, Умард Ирланд 5.9, Польш улс 3.1 хувийг шүүхийн байгууллагад зарцуулдаг бол манай улс 0.46 хувьтай байна. Эндээс дүгнэхэд эдийн засаг хүнд байдалд байгаа ч гэсэн шударга байдлын талд зогсдог шүүхийн санхүүгийн төвшинг бууруулах шаардлага байхгүй олон улсын жишгийг дагаж мөрдмөөр байна” хэмээсэн юм. Түүнчлэн шүүгчдийн цалинг нэмэгдүүлснээр шүүгчдийн авлига багасна эсвэл цалин буурахаар авлига нэмэгдэнэ гэсэн асуудал байхгүй. Цалинг нэмснээр шударга шүүгчид хувийн амьдралдаа санаа зовохгүйгээр ажилдаа илүү анхаарал хандуулахад чухал хувь нэмэр үзүүлэх бөгөөд авлига авах эрсдэлийг багасгана.Түүнээс биш цалин их ч, бага ч авлига авна гэсэн үг биш юм. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн зургадугаар зүйлийн 6.7 дахь хэсэгт шүүгчийн цалингийн хэмжээг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг харгалзан УИХ-аар тогтооно гэж заасан байдаг бол Засгийн газар энэ хуулийг зөрчиж, шүүгчийн цалинг буулгах гэж байгаа нь шударга асуудал биш гэдгийг хуралд оролцогчид илэрхийллээ.

# Г.СЭДЭДСҮРЭН: ЕСӨН ПОСТОНД АРИУТГАЛЫН АЖИЛ ЭХЛҮҮЛСЭН

Н.БАТЗАЯА

*Нийслэлийн Онцгой байдлын газраас өчигдөр мэдээлэл хийлээ. Энэ үеэр НОБГ-ын ГУСХ-ийн мэргэжилтэн Г.Сэдэдсүрэнгээс цаг үеийн асуудалтай холбогдуулан зарим зүйлийг тодрууллаа.*

**-Нийслэлд ойрхон газруудад малын цэцэг болон шүлхий өвчин гарсан. Энэ өвчнөөс урьдчилан сэргийлэх ямар арга хэмжээ авч байна вэ?**

-Малын гоц халдварт өвчин гарсантай холбогдуулан нийслэлийн Засаг даргын 594 тоот захирамж гарсан. Энэхүү захирамжийн хүрээнд нийслэл дэх шалган нэвтрэх есөн товчоонд 24 цагийн хөдөлгөөнт эргүүл гарч байна. Тухайлбал, Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Баруунтуруун болон Эмээлтийн товчоогоор нийт 152 тарвага нэвтрүүлэхийг завсдан иргэдийг таслан зогсоолоо. Хурааж авсан тарвагыг холбогдох албаны хүмүүст хүлээлгэн өгсөн. Мөн Зооноз судлалын үндэсний төвөөс тахлын сэжиг илэрсэн тохиолдол бүрт ариутгал, халдваргүйжүүлэлт хийж байна. Түүнчлэн Улаанбаатар хоттой ойр байрлах Төв аймгийн Сэргэлэн сум, Говь-Сүмбэр аймгийн Сүмбэр суманд малын гоц халдварт шүлхий, цэцэг өвчин гарсан. Үүнтэй холбогдуулан Багахангай, Баянзүрх, Налайх дүүргийн IV дүгээр зөрлөгийн шалган нэвтрэх товчоонд малын эмч нар ариутгал, халдваргүйжүүлэлтийн пост гарган ажиллаж байгаа. Хэдийгээр нийслэлд шүлхий өвчин гараагүй ч орж ирэхгүй гэх баталгаагүй. Учир нь халдварт өвчин гарсан газруудаас нийслэлээс 200 км-ийн зайтай. Хичээл, сургууль эхлэхтэй зэрэгцээд малчид малаа амьдаар борлуулах сонирхолтой байдаг. Тиймээс малаа тээвэрлэж нийслэлд авч ирдэг. Тэгэхээр мал тээвэрлэсэн машинаар дамжин нийслэлд халдвар тархах өндөр магадлалтай. Энэ бүгдэд тодорхой арга хэмжээ авч, ариутгалын ажлыг хийж гүйцэтгэж байна. Багахангай дүүрэгт вакцинжуулалт хийж эхэлсэн, ажлын явц 70 гаруй хувьтай байгаа. Мал эмнэлгийн газраас Улсын мал эмнэлгийн үржлийн газартай хамтран Багахангай дүүргийн I, II хороонъ 350 малаас цусны дээж цуглуулан шүлхийн дэгдэлтийн үеийн тандалт судалгааг хийж эхэлсэн.

**-Шүлхий өвчний талаар мэдээлэл өгөхгүй юу?**

-Уг өвчин нь салаа туурайтай мал, амьтдыг өвчлүүлдэг. Богино хугацаанд маш хурдан тархаж, үлэмж хэмжээний газар нутаг, улс орныг, хамран гардаг онцаюултай гоц халдварт өвчин. Шүлхийгээр үхэр, хонь, ямаа, тэмээ, гахай болон зэрлэг туруутан амьтад буга, цаа буга, хандгай, цагаан зээр зэрэг амьтад өвчилдөг. Энэхүү өвчин нь хүнд агаар дуслын, бэлгийн зам, хоол боловсруулах гэсэн гурван замаар халдварлана. Хэрэв өвчтэй малын сүү, цагаан идээг идвэл халдвар авах магадлалтай. Өвчтэй хүнээс эрүүл хүнд халдварладаггүй. Харин дээрх тохиолдолд л халдварладаг. Гэхдээ хүнд бараг халдварлаад байдаггүй.

**-Ямар шинж тэмдэг илэрдэг вэ?**

-Энэ өвчинд нууц үе гэж бий. Нууц үе нь 3-8 долоо хоног үргэлжилдэг. Гэнэт 38-39 хэм хүртэл халуурах, чичрэх, толгой, булчин, үе нурууугаар өвдөх шинж тэмдэг илэрнэ. Мөн ам нь хуурайшин хорсох, юм зажлахад өвдөх, шүлс их гоожих, ам, хамрын салст, нүдэнд, гадна арьсанд цэврүү гардаг. Энэ тохиолдолд иргэд яаралтай эмчид хандах хэрэгтэй. Ер нь аль болох өвчтэй малын, тэр дундаа салаа туурайтай малын махыг идэхгүй байх хэрэгтэй. Тэгж байж уг өвчнөөс урьдчилан сэргийлж чадна.

**-Сүүлийн үед иргэд зөвшөөрөлгүй самар түүж, худалдаж байна. Амиа алдах тохиолдол ч гарсан?**

-Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 онд гаргасан 166 дугаар тушаал бий. Уг тушаалд хуш модны самрыг тухайн оны аравдугаар сарын 15-аас гуравдугаар сарын 15-ны хооронд үйлдвэрийн аргаар боловсруулахыг зөвшөөрсөн байдаг. Үүнээс хойш болон өмнө түүж, бэлтгэхийг хориглосон. Энэ жил тухайн нутаг орны онцлог, байгаль цаг уурын нөхцлөөс хамаарч самрын болц харилцан адилгүй байна. Тухайлбал, Архангай, Өвөрхангай аймагт самрын болц гүйцсэн. Иргэд хушны самрыг хууль бусаар түүн, зарж худалдаалах нь ихэслээ. Ингэхдээ хуш модыг маш ихээр гэмтээж, гал түймэр гарах нөхцлийг бүрдүүлдэг. Цаашилбал, өөрсдөө модноос унаж бэртэх, улмаар амиа алдах тохиолдол ч гарсан. Эдгээр эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд ЦЕГ, НМХГ, Байгаль орчин, ногоон хөгжлийн газар, НОБГ хамтран 14 хоногийн аян зарлахаар болсон. Аяны хүрээнд нийслэлийн ногоон хөгжлийн бүс буюу самар ургаж байгаа аманд хөдөлгөөнт эргүүл гаргана. Цагдаагийн ерөнхий газар, Байгаль орчин, ногоон хөгжлийн газрын байгаль хамгаалагч нар өглөө, оройн цагт зуслангийн замаар орж, иржс байгаа тээврийн хэрэгсэлд шалгалт явуулна. Зөвшөөрөлгүйгээр самар түүсэн, байгалийн дагалдах баялгийг ашигласан иргэдэд холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авна.

**-Нийслэлд модноос унаж амиа алдсан тохиолдол гарсан уу?**

-Нийслэлийн нутаг дэвсгэрт модноос унаж, амиа алдсан тохиолдол гараагүй. Харин улсын хэмжээнд бол гарсан.

PHOTO NEWS



*Рио-2016 Олимпийн наадмын чөлөөт бөхийн 65 кг-ын жинд зодоглосон Монгол Улсын Гавьяат тамирчин Г.Мандахнаран Узбекистаны бөхийг ялж, хүрэл медаль хүртэх боломжоо цагийн төгсгөлд алдсан билээ. Тэгээд түүнд Монголын чөлөөт бөхийн мастеруудын холбоо шижир алтаар урласан медаль хийж өгөх хандивын үйлсийг эхлүүлсэн. Ингээд өчигдөр Г.Мандахнаранд шижир алтаар урласан медаль, 20 сая 417 мянган төгрөгийг гардуулан өглөө.*

## О.Мэндсайхан: Зам ашигласны төлбөр нэмэгдсэнийг иргэд мэдэхгүй байна

Монгол Улсын Засгийн газраас авто зам ашигласны төлбөрийн хэмжээг нэг дахин нэмэгдүүлэх тухай 103 дугаар тогтоолыг өнгөрсөн хоёрдугаар сард гаргасан билээ. Тус тогтоолын дагуу 12 хүний суудалтай тээврийн хэрэгсэлд 1000 төгрөг, 12-24 хүний суудалтай тээврийн хэрэгсэл 2000, 24-өөс дээш хүний суудалтай тээврийн хэрэгсэл 3000 төгрөг авахаар болсон байна. Харин хоёр тэнхлэгтэй 3.5 тн хүртэл бодит жинтэй тээврийн хэрэгслээс 2000, гурван тэнхлэгтэй 18 тн хүртэл бодит жинтэй тээврийн хэрэгсэл 4000, дөрвөөс дээш тэнхлэгтэй 25 тн-оос дээш жинтэй тээврийн хэрэгслээс 10 мянган төгрөг хураахаар болжээ. Уг тогтоол хэрэгжээд долоон сар өнгөрсөн хэдий ч иргэд мэдээлэлгүйгээс болж уурлаж, бухимдах, улмаар мөнгө хураагчдыг доромжлох, биед нь халдах тохиолдол гарсаар байгаа гэнэ. Энэ талаар Гуртын гүүрний төлбөр хураагч О.Мэндсайхан “Иргэд зам ашигласны төлбөр нэмэгдсэнийг төдийлөн мэдэхгүй байна. Түүнээс болж уурлаж бухимдах тохиолдол их гардаг. Засгийн газрын тогтоолын дагуу тавдугаар сарын 1-ны өдрөөс эхлэн нэмсэн төлбөрийг хурааж байгаа. Тухайн машины даац болон суудлын тооноос хамаарч харилцан адилгүй үнэтэй байгаа. Засгийн газрын тогтоолын дагуу мотоциклиос 500, ачааны зориулалттай тээврийн хэрэгслээс даац, тэнхлэгээс нь хамаарч 2-10 мянган төгрөг хурааж байгаа. Бид бүтэн 24 цаг ажилладаг. Зөвхөн төлбөр хураах л үүрэгтэй. Иргэд үүнд хүлээцтэй хандаж, зам ашигласны төлбөрөө хураалгаарай гэж хэлмээр байна” гэсэн юм. Монгол Улсын хэмжээнд нийт 15 төлбөр хураах цэг байдаг бөгөөд дээрх цэгүүдэд зам ашигласны төлбөр нэмэгджээ. Дашрамд сонирхуулахад, зам ашигласны төлбөрийг ажлын гурав хоногт багтаан улсын авто замын сангийн дансанд шилжүүлдэг байна. Харин тус сангийн дансан дахь мөнгийг авто замын засвар арчлалтын ажил, замын тэмдэг, тэмдэглэгээ болон төлбөр авах цэгийн үйл ажиллагааны зардалд зарцуулдаг юм байна.

ХҮЧИНГҮЙД ТООЦОВ

Регистерийн дугаар:5525608 Ар Жэй Эйч ХХК -ний байгууллагын тамга алга болсон тул хүчингүй болгож өгнө үү. Утас:97032420

## Эхнэрээ хөнөөсөн этгээдэд 24 жилийн ял оноолоо

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн VI дугаар хорооны нутагт байрлах нэгэн зочид буудалд “Эхнэрээ архи уулаа” хэмээн зодож, амийг нь хөнөөсөн байж болзошгүй онц ноцтой хэрэг энэ оны дөрөвдүгээр сард гарсныг өмнө бид мэдээлсэн билээ. Тодруулбал, өнгөрсөн дөрөвдүгээр сарын 04-05-нд шилжих шөнө тус хорооны нутагт байрлах нэгэн зочид буудалд хүн амины хэрэг гарлаа гэх дуудлага цагдаагийн байгууллагад ирсэн байна. Дуудлагын дагуу цагдаагийн алба хаагчид хэргийн газарт очихоод гурван иргэн байсан бөгөөд нэг нь амиа алдаж, нэг нь тархиндаа хүнд гэмтэн байдалтай байсан аж. Уг хэргийг Сүхбаатар дүүргийн цагдаагийн хэлтсийнхэн шалгаж, А гэгчийг сэжигтнээр тооцон, баривчилжээ. Тэрбээр, талийгаач Н-ын нөхөр бөгөөд “архи, пиво уулаа” гэх шалтгаанаар маргалдаж, улмаар түүний аминд хүрсэн гэдгээ хүлээсэн байна. Түүнчлэн Сүхбаатар дүүргийн прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйлийн 91.2.2, 91.2.12, 91.2.15 дахь хэсэгт заасанаар ялах дүгнэлт үйлдэн тус дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлсэн юм. Шүүх энэ хэргийг 2016 оны долдугаар сарын 29–ний өдөр хэлэлцэж, О.А-г Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 24-р зүйлийн 24.1-д заасныг үндэслэн "онц аюултай гэмт хэрэгтэн"-ээр тооцжээ. Мөн Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.2, 91.2.12, 91.2.15 дах хэсэгт заасанаар 24 жил, 181-р зүйлийн 181.3 дахь хэсэгт заасанаар 5 жил 6 сар хорих ял ногдуулжээ. Ингэхдээ 10 жилийн хорих ялыг гяндангийн, сүүлийн 14 жилийн хорих ялыг онцгой дэглэмтэй эрүүгийн хоригдох ангид эдлүүлэхээр шийдвэрлэсэн байна. Дашрамд дурьдахад, яллагдагч А нь урьд нь дөрвөн удаа ял шийтгүүлэхдээ хоёр удаа хүнд гэмт хэрэг үйлдэж, ял эдэлж байжээ.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## Ихэнх нутгаар бороо орж, хүйтэрнэ

Энэ сарын 30, 31-нд нутгийн зүүн хагаст, ездүгээр сарын 1-нд баруун болон зүүн аймгуудын нутгаар, 2-нд ихэнх нутгаар дуу цахилгаантай бороо орно. Энэ үед салхи 30, 31-нд говь, талын нутгаар, 1, 2-нд зарим газраар секундэд 12-14 метр хүрч ширүүсэх юм байна. Мөн Нутгийн зүүн хэсгээр сэрүүсч Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтэйн уулархаг нутгаар шөнөдөө 0-5 градус, өдөртөө 13-18 градус, говийн бүс нутгийн өмнөд хэсгээр шөнөдөө 10-15 градус, өдөртөө 21-26 градус, бусад нутгаар шөнөдөө 5-10 градус байхыг Ус цаг уурын орчны хүрээлэнгээс анхааруулаалаа.


# ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо:2016-08-29
Тендер шалгаруулалтын нэр: Эрдэнэ багийн авто замын гэрэлтүүлэг
Тендер шалгаруулалтын дугаар: OP-195/2016

Орхон аймгийн засаг даргын тамгын газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос Эрдэнэ багийн авто замын гэрэлтүүлэг ажил–ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 50,000 /тавин мянган/ төгрөгөөр худалдан авч болно.

Тендерийн баримт бичгийн үнийг доорхи дансаар тушаана.

Төрийн сан

Дансны дугаар: 210051009

Хүлээн авагч: Орхон аймгийн ХАА-ны алба

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Тусгай зөвшөөрөл: Эрчим хүчний яамны 03.2.1, 03.2.2, 03.2.3, 03.2.4, 03.2.5 заалтуудын аль нэг нь байх шаардлагатай.

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил (2014, 2015 он)

Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх

Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн [1%] төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2016 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 09 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2016 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 09 цаг 30 минутанд нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Орхон аймгийн ЗДТГ, Нутгийн удирдлагын ордон**
**1 давхар 113 тоот өрөө Утас:70358570**

# ЗАВСАРЛАГА

ОДДЫН ЦАГ

Орчуулсан: Б.ДАВААХҮҮ

*Японы тамирчин Ичо Каори бол чөлөөт бөхийн босоо аварга. Гэхдээ 20 гаруй жилийн турш чөлөөт бөхийн дэвжээнд тасралтгүй аваргалсан түүнийг Монголын бөх П.Орхон өвдөг шороодуулж, ялалтынх нь буухиаг тасалдуулсан түүхтэй. Энэ ялагдлын дараа хүч нь харьжээ гэх шүүмжлэлд өртсөн тамирчин суут аварга гэдгээ Риогийн олимпод баталж, дөрвөн олимпод дараалан түрүүлсэн анхны эмэгтэй чөлөөт бөхийн тамирчин болсон юм. Тиймээс энэ удаагийн “Оддын цаг” буландаа Японы суут бөх Ичо Каоригийн орон нутгийн хэвлэлд өгсөн товчхон ярилцлагыг орчуулан хүргэж байна. Тэрбээр тус ярилцлагад манай бөх П.Орхоны талаар мөн дурьджээ.*



# ИЧО КАОРИ:

## ОЛИМПОД П.ОРХОНТОЙ ТААРЧИХ ЮМСАН ГЭЖ БОДОЖ БАЙЛАА

**-Олимпод дөрвөн удаа түрүүлсэн анхны эмэгтэй чөлөөт бөхийн тамирчин болсон. Сэтгэгдэл ямар байна?**

-Дөрөв дэх олимпдоо түрүүлсэн гэдэгтээ нэг л итгэж өгөхгүй байсан шүү. Харин одоо медалиа хараад алтан медаль авсандаа итгэж байна. Сэтгэл уужраад сайхан байна.

**-Дөрөвхөн секунд үлдээд байхад өрсөлдөгч тамирчнаа ялж, алтан медаль хүртсэн шүү дээ. Барилдааны явцад хэцүү санагдаж байв уу?**

-Тэмцээний цагийг хараад найдвар бараг үлдсэнгүй дээ гэж бодсон. Гэхдээ цаг арай дуусчихаагүй байгаа учраас довтлох хэрэгтэй гэж бодож байлаа. Гэтэл өрсөлдөгч маань түрүүлж довтлох үед энэ миний сүүлийн боломж гэж бодон, ялахын төлөө барилдсан.

**-Барилдааны дараа өгсөн ярилцлагадаа ялагдахаас айж байсан тухайгаа ярьсан байсан. Ямар учиртай юм бэ?**

-Олимпод ялна гэж шууд хэлж чадахгүй байсан учраас тэр. Японыг төлөөлөн Олимпод явах хүсэлтэй ч, явж чадаагүй маш олон чадварлаг бөхчүүд бий. Тиймээс би Японыг төлөөлж байгаа учраас заавал ялах ёстой юм шүү гэсэн нэг төрлийн сэтгэлзүйн дарамт надад байсан.

**-Мөн та “хамгийн сүүлд ээж минь надад тусалсан” гэж ярьсан байна билээ. Ээж тань юу гэж хэлэх байсан бол?**

-Хамгийн сүүлд ээж минь надад тусалж, би алтан медаль авсан. Ээж минь байсан бол сайн байлаа, баяр хүргэе гэж хэлэх байсан байх гэж бодож байна.

**-Энэ жил Монголын бөхөд ялагдаж, ялалтын буухиагаа тасалсан. Магадгүй тэр ялагдал Риогийн олимпоос алтан медаль авахад нөлөөлсөн байх?**

-Тийм шүү. Тэр тамирчинтай энэ удаагийн олимпод таарчих юмсан гэж бодож байсан юм. Гэвч өөр хэсэгт хуваарилагдаад, финалд гарч ирж чадаагүй байна билээ. Тэр охины ачаар би чөлөөт бөхийг дахин нэг удаа эргэж харахад хүрсэн. Түүнд талархаж байна.


ТЭНГИС
КИНО ТЕАТР



Еврейн нөлөөтэй гэр бүлээс гаралтай Бен-Хур-аас ромын иргэн хамгийн сайн найз нь урваж боол болгоно. Оргож эх орондоо ирээд өшөөгөө авна.

Хэнмэдэх сүүлийн 15 жил 23 ажлаас халагджээ.Уул нь тэр цахилгааны инженер болох хүсэлтэй ч хувь тавилан тэрнийг хааш нь ч хамаагүй аваад шидчихдэг гэхэд болно.Сүүлийн удаа тэр ажлаасаа халагдсанаа эхнэртээ хэлсэнгүй тас нуужээ.

Харин Ананд бол дээд зиндааны залуу.Түүний эцэг маш баян бөгөөд Ананд хар багаасаа мөнгөөр туйлж өссөн гэхэд болно.Тэр өдөр нь унтаж шөнө нь гардаг зуршилтай жинхэнэ шоучин залуу...

Хэнмэдэх эхнэр хүүхдээсээ нууцаар машин түрээсэлж халтуур хийдэг болжээ. Харин нэг өдөр түүний таксинд үл таних нэгэн залуу суусан нь тэдний хувьд чухал уулзалт болж үйл явдал сонирхолтойгоор үргэлжилнэ. Нэг өдрийн дайсан нөгөө өдрийн анд ч байж мэдэх шүү дээ...



Тэнгисийн дэлгэцэнд удахгүй гарах кино


Гарах хугацаа 2016.09.02


Гарах хугацаа 2016.09.09


Гарах хугацаа 2016.09.02


Гарах хугацаа 2016.09.30


Гарах хугацаа 2016.9.23


Улаанбаатарт:

| Маргааш | | Нөгөөдөр | |
|---|---|---|---|
| Өдөр | +21 | Өдөр | +19 |
| Шөнө | +8 | Шөнө | +8 |

## Өдрийн зурхай



**Аргын тооллын:**
*2016 оны 08-р сарын 30, Мягмар гараг*

**Билгийн тооллын:**
*Намрын тэргүүн улаан бичин сарын шинийн 28. Найман цагаан мэнгэтэй Хөх бич өдөр. Ангараг гараг*

**Наран ургах/шингэх:**
*07:10 / 20:39*

**Үс засуулбал:**
*Хэрүүл тэмцэл ирнэ.*

Тухайн өдөр хулгана, луу жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, сан тавиулах, угаал үйлдэх, бүжиг наадам хийх, цэцэрлэг байгуулах, урлан бүтээхэд сайн. Хувцас эсгэх, шинэ хувцас өмсөх, зөвлөгөө хийх, сэтгэлд сэвтэй газар очиход муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохойболой. Хол газар яваар одогсод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр ургээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

## Бидэнд тохиолдсон хүндхэн хөгтэй явдлууд



### Уртнасан Уртаа

Автобусанд явж байсан чинь хажууд сууж байсан эгчийн утас нь дуугараад:

-Байна уу? За тэгээд наадахнаас чинь ямар юм төрөв? гэсэн цаанаас нь “охин” л гэсэн бололтой. Тэгсэн чинь эгч:

-Өө охин юм уу. Балай юм аа. Одоо тэгвэл хүн амьтанд өг өг гээд л ярьж өгч байна аа. Хүмүүс гайхаад л аймаар харсан чинь эгч тоож байгаа ч шинж алга “Одоо хая, хая” гээд л нэг их аймаар яриад л. Тэгээд ярьж дуусаад хүмүүсийг анзаарсан бололтой

-Өө, манай банхар харин гөлөглөжээ гээд инээдэг байгаа.



### Б. Эрдэнэбат

Сая нэг хүний түүх уншаад санаанд орлоо. Нэг ах эхнэртэйгээ танилцсан түүхээ ярьж өгч байсан юм.

Тэр ах нэг дажгүй бүсгүйг харж дурлаад холоос хараад л явдаг байж л дээ. Нөгөө бүсгүйтэйгээ ойролцоо амьдардаг тул өглөө ажилдаа явахад нь дагаад л, орой ажлаас тарахад нь ч холхон зайнаас дагаад явдаг байж. Нэлээд хэд хоног дагасны дараа нөгөө бүсгүй анзаарч гаж донтон ухааны юм бодоод зугтаж, бөөн юм болсон юм байх аа. Заримдаа ажлынхаа залууг гуйгаад хамт явдаг байсан гэсэн. Манай ах хүү болохоор явж очоод танилцая гэхээр хэт ичимхий бас өөрийгөө голоостой. Тэгээд л холоос хараад л санаа алдаад л дагадаг байж. Яваандаа нөгөө бүсгүй ч айхаа больсон гэсэн. Гэтэл нэг өдөр хөдөөнөөс аав нь ирээд нөгөө ах хүү 3 хоног нөгөө бүсгүйгээгээ дагаж чадаагүй гэнэ. 3 хоногийн дараа орой нь нөгөө бүсгүйгээ дагах гээд л ажлынх нь гадаа хүлээж байтал өнөөх бүсгүй нь гарч ирсэнээ л ийш тийшээ харж байснаа нэлээд урам муутай алхаж явна гэнэ. Ах хүү нуугдаж байсан газраасаа гараад л хойноос нь дагаад эхэлсэн чинь нөгөө бүсгүй эргэж харснаа нэлээд уууртай түргэн түргэн алхаад байна гэнэ. Тэгснээ эргэж харж зогссоноо “Хэд хоног хааччихдаг юм” гэсэн гэдэг. Нөгөө ах гайхаад л бас баярлаад зогсож байтал “Дагаад байлгүй хажууд яваач тэнэг юм уу” гээд л нэлээд уууртай хэлсэн гэсэн. Дасаж дурлана гэдэг л энэ байх даа хөөрхий.



### Ундрах Ундак

Ажлаар хөдөө явж байсан юм. Тэгсэн цуг явж байсан нэг залуу “Ганц хуруудчихлаа. Яах вэ” гэж байна. Тэгсэн цуг явж байсан нэг ах “Буцалсан хар цайнд хуруугаа дүрчихдэг юм. Тэгээд гурил зуурч байгаад хуруун дээрээ тавиад, гялгар уутаар боогоод унтчих” гэлээ. Манай хүн ч яах вэ, хар цай чаначихаад л буцлангуут нь хуруугаа дүрэх гэснээ нэг л халшраад л, эвгүй юм бэ гээд байсан чинь нөгөө ах харин “Юундаа айсан юм. Наад хуруу чинь борлоод болчихгүй нь л лав. Алив хуруугаа дүр. Би гар дээрээс чинь дараад өгье” гээд л дайрлаа. Тэгээд нөгөө залуу “Яа яа аймаар халуун байна” гээд буцалсан цайнд хуруугаа дүрж гаргаж ирчихээд хуруугаа харж байснаа “Өө буруу хуруугаа дүрчихсэн байна ш дээ” гэдэг байгаа.